

DETERMINANTS OF UNPAID LABOR AND HOUSEWORK AND CARE WORK USING TIME USE SURVEY DATA: EVIDENCE FROM RURAL HERDERS OF MONGOLIA

Amartuvshin Amarjargal¹

Lkhagvaa Dansranbavuu²

¹ University of the Humanities, Mongolia

² Mandakh University, Mongolia

Abstract. The aim of this study is to identify the factors influencing time use among members of rural administrative centers and herding households in Mongolia. Specifically, it seeks to clarify the impact of various factors on the time allocated to informal employment (jobs without direct wages) and unpaid household work, such as domestic tasks. To achieve this, the study analyzed current time-use patterns and their determinants among rural administrative center residents and herding households, using data from time-use surveys conducted in 2011, 2015, and 2019, applying simple regression methods. Another objective of this research is to argue that unpaid labor and unvalued household work should be examined separately. Although both fall within the informal sector, this study aims to reveal how their economic implications differ between household roles, particularly in terms of gender. Unpaid work includes non-market activities such as household chores, child care, and caring for the elderly and sick family members. The results of the regression analysis show a significant gender gap in informal employment and unpaid work in rural areas. Compared to women, men are more likely to engage in unpaid work related to livestock herding and animal product processing, whereas women devote more time to household chores and caregiving. Furthermore, unpaid work is strongly associated with educational attainment: individuals with little or no education are more likely to engage in unpaid work.

Keywords: Informal sector, Unpaid work, Unvalued work, Gender gap, Education level, Time-use survey data 2011, 2015, and 2019

¹amaraa@humanities.mn

²dansranbavuu@mandakh.edu.mn

ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ЦАЛИН ХӨЛСГҮЙ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭГҮЙ ГЭРИЙН АЖИЛД
НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ЦАГ АШИГЛАЛТЫН
СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛД ҮНДЭСЛЭН ШИНЖЛЭХ НЬ

А.Амаржаргал³

Л.Дансранбавуу⁴

¹ Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль,

² Мандах Их Сургууль

Хураангуй. Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын хөдөө орон нутгийн сумын төвийн болон малчин өрхийн гишүүдийн цаг ашиглалтанд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоход оршино. Тэр дундаа, малчин өрхийн албан бус хөдөлмөр эрхлэлт (шууд цалин хөлс авдаггүй ажил) болон үнэлгээгүй ажил буюу гэрийн ажилд зарцуулах хугацаанд нөлөөлж буй хүчин зүйлийн нөлөөллийг тодруулахыг зорилоо. Үүний тулд 2011, 2015 болон 2019 оны цаг ашиглалтын түүвэр судалгааг ашиглан, хөдөө орон нутгийн сумын төвийн болон малчин өрхийн гишүүдийн цаг ашиглалтын өнөөгийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг энгийн регрессийн аргыг ашиглан шинжиллээ. Энэхүү судалгааны бас нэгэн зорилго нь цалин хөлсгүй хөдөлмөр болон үнэлгээгүй гэрийн ажлыг ялгаа заагтай авч үзэх ёстой гэдэг санааг дэвшүүлж хэдийгээр эрэгтэй эмэгтэй аль аль нь албан бус салбарт харьяалагддаг утгаараа адил төстэй боловч эдийн засгийн агуулгын хувьд хоёр өөр өрхийн ажил үүрэгт хүйсийн ялгаатай байдал хэр зонхилж байгааг олж илрүүлэхийг зорилоо. Үүнд үнэлгээгүй ажилд зах зээлд үнэлэгддэггүй гэрийн ажил, үр хүүхэд, өндөр настан, өвчтэй өрхийн гишүүдийг асрах зэрэг өрхийн дотор эрхэлж ажил үйлчилгээг авч үзлээ. Энгийн регрессийн шинжилгээний үр дүнд, хөдөө орон нутгийн албан бус хөдөлмөр эрхлэлт болон үнэлгээгүй ажилд хүйсийн ялгаа чухал байр суурийг эзэлж байгаа нь харагдаж байна. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрчүүд нь цалин хөлсгүй хөдөлмөр, тэр дундаа мал маллах, малын бүтээгдэхүүн боловсруулах гэх мэт ажил эрхлэх түлхүү хандлагатайг, мөн эмэгтэйчүүд нь үнэлгээгүй ажилд буюу гэрийн ажил, хүүхэд хөгшид асрах зэрэг ажилд илүү их цаг зарцуулж байна. Цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэлт боловсролын түвшинтэй шууд хамааралтай байгаа бөгөөд ялангуяа боловсролгүй эсхүл бага боловсролтой байх нь цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэх нөхцөл болж байна.

Түлхүүр үг: албан бус салбар, цалин хөлсгүй ажил, үнэлгээгүй ажил, хүйсийн ялгаа, боловсролын түвшин, цаг ашиглалтын түүвэр судалгааны өгөгдөл 2011, 2015 ба 2019

³ amaraa@humanities.mn

⁴ dansranbavuu@mandakh.edu.mn

Оршил

Бидний судалгааны зорилго нь хөдөө орон нутгийн сумын төвийн болон малчин өрхийн гишүүдийн цаг ашиглалтын түүвэр судалгаанд үндэслэн тэдний цаг ашиглалтанд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлж, цалин хөлсгүй ажил болон үнэлгээгүй ажлын ялгааг тодруулан авч үзэж өрхийн гишүүдийн хүйсийн нөлөөлөл дээрх хоёр төрлийн хөдөлмөрт ялгаатай тусч байгаа эсэхийг тодорхойлоход оршино. Цалин хөлсгүй ажил болон үнэлгээгүй ажлын аль аль нь албан бус салбарт тооцогддог. Аливаа улс орны үндэсний тооцооны системд албан бус салбарыг хамруулах судалгаа зарим арга аргачлал тодорхой түвшинд боловсруулагдаж байгаа хэдий ч энэхүү салбарын үйл ажиллагааны талаар бүртгэл хангалтгүй, мэдээллийн хүртээмж муу, татвар, нийгмийн даатгалд тэр бүр хамрагддаггүй зэрэг шалтгаанаас үүдээд албан бус салбар үргэлж далд эдийн засгийн нэг хэсэг болсоор ирсэн. Хөгжиж буй улс орны эдийн засагт албан бус салбар чухал үүрэгтэй байдаг гэдэг утгаараа мөн энэхүү мэдээллийн хомс байдал, аливаа эрхзүйн харилцаанаас гадуур байдал нь тус салбарыг судлах, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлоход хүндрэл учруулдаг. Иймд ОУВС, ОУ-ын хөдөлмөрийн байгууллага, ҮСХ зэрэг олон газраас албан бус хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн байдлын судалгаа зэрэг тодорхой судалгааг авч энэхүү салбарыг үнэлэх оролдого хийж ирсэн байгаа нь харагддаг. Гэсэн хэдий ч эдгээр судалгаа нь үргэлж цалин хөлсгүй хөдөлмөрийг түлхүү судалж түүний нэмүү өртгийг тодорхойлох, цалин хөлсгүй хөдөлмөрийг эхэлж байгаа хүн амын тоог илрүүлэх гэх мэт үргэлж цалин хөлсгүй ажлыг томруулан харах судалгаа зонхилж байдаг нь учир дутагдалтай байна.

Харин зах зээлд үнэлэгддэггүй, тухайлбал үр хүүхдээ харах, настай эцэг эх, өвчтэй хэн нэгнээ асрах, гэрийн ажлаа хийх гэх мэт ажлыг дээр дурьдсан аль ч судалгааны хүрээнд тодорхой авч үзээгүй бөгөөд харин 5 жил тутамд хийгддэг цаг ашиглалтын түүвэр судалгаа нь энэхүү үнэлгээгүй ажлын нөхцөл байдлыг үнэлж судалж, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлох боломжийг олгож байна. Магадгүй зарим судлаачид гэрийн ажлыг ч мөн зах зээлд орлуулах үйлчилгээний үнэ ханшаар үнэлэх бүрэн боломжтой гэж маргаж болох хэдий ч бид үзэхдээ гэрийн эзэгтэйн гэртээ чанасан цай, хоол болгоныг зах зээл дээр аваачиж үнэлэх боломж бараг байхгүй, харин гэртээ хариулж, өсгөсөн ямарч хонийг шууд зах зээл дээр борлуулах боломжтой гэдэг утгаар нь цалин хөлсгүй ажил болон үнэлгээгүй ажлын хоорондын зааг ялгааг энэхүү судалгаанд тавьж байгаа билээ. Ингэснээр албан бус салбар гэдэг том хаягны дор бүрэн орхигдуулж байгаа гэрийн үнэлгээгүй ажлын нөхцөл байдлыг хөдөө орон нутгийн иргэдийн хүрээнд судалж, ялангуяа хүйсийн нөлөө эдгээр үнэлгээгүй ажилд ямар нөлөө байгааг судалж гаргаж ирсэнээр албан бус салбарыг бид давхар өнцгөөс харж түүнд үгүйлэгдэж байгаа бодлогын зохицуулалтыг нээж илрүүлэх боломжийг олгоход энэхүү судалгааны ажлын ач холбогдол оршино.

Манай улсын ҮНБ-ий 10.1%-ийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна (ҮСХ, 2023).

Тэр дундаа, 2023 оны байдлаар, мал аж ахуйн салбарт 189 мянга гаруй малчин өрх байгаа бөгөөд улсын хэмжээнд 298 мянган малчин, нийт 64.6 сая малыг маллаж байна. Эдгээр 189 мянган өрхийн аж ахуйд суурилсан мал аж ахуйн салбар нь албан бус салбарын томоохон хэсгийг бүрдүүлдэг. Малчид ажиллах хүчний 23.2%-г, улсын хэмжээний нийт өрхийн 19.2%-г малчин өрх, харин хөдөө орон нутгийн хүн амын 29%-г малчид эзэлж байна. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн 80 орчим хувийг бүтээдэг ч гэсэн дийлэнх үйлдвэрлэл нь малчин өрхийн уламжлалт арга барилаар явагддаг. Өрхийн үйлдвэрлэлийн нэг онцлог нь хувийн хэрэгцээнд тулгуурласан, амиа аргацаах шинжтэй бөгөөд өөрсдийн хэрэгцээнээс давсан илүүдэл бүтээгдэхүүнээ зах зээлд санал болгодог. Мөн, өрхийн үйлдвэрлэл нь өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн боломжит цагаар хязгаарлагдах тул малчин өрхийн үйлдвэрлэлийн функцэд цалин гэдэг ойлголт байхгүй. Ингэснээрээ, малчин өрхийн үйлдвэрлэлийг ашиг орлого олохын төлөө чөлөөт зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг пүүс, компанийн ашиг хамгийн их байлгах зарчмаас эрс ялгаатай болгож, албан бус, амиа аргацаасан шинж чанартай болгодог (Chayanov, 1991). Сонгодог эдийн засгийн онол нь өрх болон пүүсүүдийн ханамж болон ашгаа хамгийн их байлгах зорилгын функцэд үндэслэдэг. Гэхдээ үүний далд төсөөлөлд, өрхийн эрчүүд цалин хөлстэй ажил эрхлэн гэр бүлээ тэжээн тэтгэж, харин эмэгтэйчүүд гэрийн ажил хийдэг гэж үздэг (Seguino, 2020). Манай уламжлалт мал аж ахуйн салбар нь албан бус хөдөлмөр эрхлэлттэй (цалин хөлсгүй ажил эрхлэлттэй) тул малчин өрхийн үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, асрахуйн болон гэрийн ажилд зарцуулах хөдөлмөрийн талаарх өрхийн шийдвэр гаргалтын асуудлыг тэр чигт нь орхигдуулж албан бус салбар гэдэг том далбаан дор зөвхөн цалин хөлсгүй ажлын талаар судалж улмаар үнэлгээгүй ажлын талаар бодлогын судалгаанд тусгахгүй орхигдуулж байна.

Малчин өрхийн доторх үйл ажиллагааг тодруулан авч үзвэл мал маллах, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэх мэт цалин хөлсгүй үйл ажиллагаа болон үр хүүхдээ асрах, гэр цэвэрлэх хоол хийх гэх мэт зах зээлийн үнэлгээгүй үйл ажиллагаа болж задардаг. Үндэсний тооцооны системд (UNSD, 2008) асрахуйн болон гэрийн ажлыг цалин хөлсгүй болон цалин хөлстэй хэмээн 2 ангилж үздэг. Цалин хөлстэй гэрийн ажил нь гэрийн үйлчлэгч хөлсөлж авах эсвэл бага насны хүүхдийг цэцэрлэгт өгөх, хүүхэд асрагч хөлсөлж авах зэрэг нөхцөлд тооцогдоно. Бид энэхүү судалгаанд, цалин хөлстэй гэрийн болон асрахуйн ажилд зарцуулах хугацааг авч үзээгүй. Учир нь ЦАС-ын судалгааны асуулгаар цалин хөлстэй гэрийн үйлчлэгч хийж байсан нөхцөлд тухайн хариулагч цалин хөлстэй ажил хийсэн гэж хариулах ба өөрийн өрхийн гэрийн ажилд зарцуулсан цаг, өөрийн үр хүүхдээ харах, өрхийн гишүүдээ асрах тэр цагаа тэмдэглэж байгаа тул тухайн малчин эмэгтэй/эрэгтэй гэртээ ямар ямар гэрийн ажил хийж байна, эсвэл үр хүүхдээ, гэр бүлийн өвчтэй гишүүдээ асрахад зарцуулж байгаа хугацаа нь бидний судалгааны тодорхойлсноор үнэлгээгүй ажил юм.

Энэхүү ажил оршил хэсэг, судлагдсан байдлын судалгаа, судалгааны ажлын логик

цар хүрээ, судалгааны эмпирик аргазүй, хөдөө орон нутгийн иргэд болон малчдын цаг ашиглалтын байдал, ЦАС-ын өгөгдлийн шинжилгээ, регрессийн үр дүн болон дүгнэлт хэсгээс тус тус бүрдэнэ. Энэхүү судалгааны зорилго нь хөдөө орон нутгийн сумын төвийн болон малчин өрхийн гишүүдийн цаг ашиглалтын түүвэр судалгаанд үндэслэн тэдний цаг ашиглалтанд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлж, цалин хөлсгүй ажил болон үнэлгээгүй ажлын ялгааг тодруулан авч үзэж өрхийн гишүүдийн хүйсийн нөлөөлөл дээрх хоёр төрлийн хөдөлмөрт хэрхэн ялгаатай тусч байгааг тодорхойлоход явдал билээ. Үүнд энгийн регрессийн шинжилгээг ашигласан бөгөөд ҮСХ-ноос гаргасан 2011, 2015 болон 2019 оны цаг ашиглалтын судалгаанд хамрагдсан баруун, хангай, төвийн болон зүүн бүсийн сум орон нутгийн иргэд болон хөдөөгийн малчдын цаг ашиглалтын мэдээллийг ашиглалан боловсруулалт хийлээ.

Судлагдсан байдлын судалгаа

Судалгааны ажлын хүрээнд хөдөө аж ахуйн албан бус салбарт ажиллаж байгаа өрх гэрийн дотор эхнэр, нөхрийн шийдвэр гаргах үйл явц, хэлцэл, мал маллах үйл ажиллагааг цалин хөлсгүй албан бус хөдөлмөр эрхлэлт гэж үзсэн үндэслэл, сүүлийн жилүүдэд хурцаар үүсч байгаа цаг уурын өөрчлөлт нь өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж байгаа зэргийг судлан үзлээ.

Bhagowalia нар судалгааны ажилдаа Бангладешийн 2007 оны Хүн ам зүй ба Эрүүл мэндийн Судалгааны мэдээллийг ашиглан эмэгтэйчүүдийн нийгэм дэх байр суурь болон хоол тэжээлийн харилцааг судалж үзсэн байдаг. Судалгаандаа, шийдвэр гаргах эрх чөлөө, чадвар, үгэн болон бие махбодын хүчирхийллийн талаарх хандлага зэрэг эрх мэдлийн үзүүлэлтүүд, эхийн боловсрол, өндрийн хэмжээ зэрэг хувьсагчид нь хүүхдийн хоол тэжээлтэй ямар хамааралтай байгааг судалсан байдаг. Логит загвар ашигласан судалгааны үр дүнгээс харахад, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах эрх мэдэл болон эхийн боломжууд өндөр байх нь хүүхдийн урт хугацааны хоол тэжээлийн байдал сайжрахтай холбоотой байсан (Bhagowalia, Menon, Quisumbing, & Soundararajan, 2012). Doss 2013 хийсэн судалгаандаа эмэгтэйчүүдийн өрхийн доторх нөөцийн хуваарилалтад хэрхэн оролцож байгааг судалсан байдаг. Судалгаагаараа эмэгтэйчүүдийн хэлэлцэх чадвар нь өрх гэрийн амжилтад үнэхээр нөлөөлдөг гэдгийг нотлон харуулсан. Ерөнхийд нь дүгнээд өрхийн дотоод харилцааны үр дүн, хэлэлцэх чадварын хүрээг өргөжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн. Судалгааны үр дүнгээс харахад, эмэгтэйчүүдийн боловсрол, орлого, хөрөнгө зэрэг нь хэлэлцэх чадварын чухал бүрэлдэхүүн хэсгүүд болж чадахыг харуулсан байна (Doss, 2013).

НҮБ-аас үнэ төлбөргүй асаргаа үзүүлэгч гэдгийг “Өрх эсвэл нийгэм доторх бусад хүмүүст асаргаа, дэмжлэгийг цалин хөлсгүйгээр үзүүлдэг хүн. Дэлхий даяар эмэгтэйчүүд төлбөргүй асаргааны ажлын ихэнхийг хийдэг бөгөөд цаг хугацааны хувьд ч тэр, мөн төлбөргүй асрагчдын олонхийг бүрдүүлдэг. Тэд нийт төлбөргүй асаргааны ажлын 75 хувиас илүүг гүйцэтгэж байна” гэж, харин төлбөргүй асаргааны ажил гэдгийг “Өрх гэр эсвэл нийгэм доторх гишүүдийнхээ сайн сайхны төлөө хувь хүнээс цалин хөлсгүйгээр

үзүүлж буй бүхий л үйлчилгээ юм. Үүнд хүмүүсийг асрах, гэрийн ажил хийх зэрэг нь орно. Түгээмэл жишээ нь хоол хийх, цэвэрлэгээ хийх, ус, түлш түүх, хүүхэд, өндөр нас-тан, өвчтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асрах зэрэг ажлууд юм. Өрхийн болон хувийн асаргааг дэмжих сайн дурын хамтын ажлууд, жишээлбэл, хамтын гал тогоо эсвэл хүүхэд асрах үйлчилгээ зэрэг нь мөн төлбөргүй асаргааны ажлын хэлбэрт тооцогдоно. Эмэгтэйчүүд, охид энэ ажлын ихэнх ачааг үүрдэг бөгөөд дэлхийн хэмжээнд тэд эрэгтэйчүүд, хөвгүүдээс гурав дахин их цагийг ийм ажилд зарцуулдаг. Төлбөргүй асаргааны ажил нь эмэгтэйчүүдийг цалинтай хөдөлмөр эрхлэх, илүү чанартай ажилд ороход саад болж буй гол хүчин зүйлсийн нэг юм” (UN, 2022) гэж тодорхойлсон байна.

Tan-Soo нар судалгаандаа, цаг уурын тогтвортой бус байдал бодитойгоор оршин байгааг тогтоосон бөгөөд үүнд дасан зохицох байдал нь өрхийн орлогоос ихээхэн хамаарч байгааг тогтоосон байна. Ийм дасан зохицох байдал нь аль ч тохиолдолд нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг илүү нэмэгдүүлж, цаг агаарын өөрчлөлтийг илүү хурдасгах магадлалтай, мөн цаг уурын өөрчлөлтийг сааруулахын тулд орлогоос гадна өрхийн гишүүдийн боловсрол, хүрээлэн буй орчны талаарх мэдлэг илүү чухал нөлөөтэй байна гэж дүгнэсэн байдаг. Үүнээс харахад, цаг уурын өөрчлөлтийн хурдыг бууруулахын тулд бодлого боловсруулагчид нь хүн амын эмзэг хэсгийн цаг агаарын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг дээшлүүлэх, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн аянуудыг өрнүүлэх шаардлагатай гэж үзсэн (Tan-Soo, Li, & Qin, 2023).

Дээрх судалгаанаас харахад, албан бус салбарыг бид нийтэд бүхлээр харахаас илүүтэйгээр өрх гэрийн доторх эдийн засгийн үйл ажиллагаа болон үнэлгээгүй ажлын хүйсийн хуваарилалтыг авч үзэх шаардлагатай харуулж байна. Цаг ашиглалтын судалгаа нь тухайн өрхийн гишүүд ямар ямар үйл ажиллагаанд ямар хугацааг зарцуулж байгааг дэлгэрэнгүй харуулсан чухал мэдээллийг агуулдаг тул албан бус салбар тэр дундаа хөдөө орон нутгийн иргэд, малчдын цаг ашиглалтанд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтооход ашиглах бүрэн боломжтой юм.

Судалгааны ажлын логик цар хүрээ:

Энэхүү судалгаагаар дээр дурьдсанчлан, мал аж ахуйн салбарын хөдөлмөр эрхлэлтийг албан бус цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэлт гэж авч үзсэн. Малчин өрхийн албан бус хөдөлмөр эрхлэлт болон үнэлгээгүй гэрийн ажилд зарцуулах цагийн зарцуулалт нь эхнэр болон нөхрийн цагаа хэрхэн хуваарилах шийдвэрээс хамаарна. Малчин өрхийн үйл ажиллагааг дараах байдлаар авч үзэв. Албан бус салбарын нэг онцлог нь өрхийн үйлдвэрлэлд суурилдаг бөгөөд өрхийн гишүүд ялангуяа эхнэр, нөхрийн шийдвэр дээр үндэслэн, ямар үйл ажиллагаанд хэн хэдэн цаг зарцуулахыг шийддэг. Өрхийн дотор эхнэр, нөхрийн хэлцлийн загвар, үр дүн, хосуудад нөлөөлөх нөлөөллийг (Bhagowalia, Menon, Quisumbing, & Soundararajan, 2012); (Doss, 2013); (Kadiyala, Harris, Headey, & Gillespie, 2014); (Mazzotta, Papaccio, & Parisi, 2019) олон судлаачид судалсан байдаг. Бидний судалгаанд, өрхийн үйлдвэрлэлд эхнэр болон нөхөр нь ямар хувь нэмэр оруулж байгааг авч үзэхийн тулд малчин өрхийн хөдөлмөрийн нийлүүлэлтийг дараах хэсгүү-

дэд хуваан авч үзлээ. Үүнд, зураг 1-д харуулсанчлан малчин өрхийн хөдөлмөрийн нийлүүлтийг 1. Албан бус хөдөлмөр эрхлэлт буюу цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэлт, 2. Үнэлгээгүй хөдөлмөр эрхлэлт, 3. Чөлөөт болон хувийн цаг гэж ангилж үзлээ. Албан бус хөдөлмөр эрхлэлт болон өрхийн үнэлгээгүй үйл ажиллагааны гол ялгаа нь албан бус хөдөлмөр эрхлэлтийн үр дүнд мөнгөн ба мөнгөн бус орлого олох боломжтой үйл ажиллагааг нэгтгэн хамруулна. Тухайлбал, малчид болон хөдөө орон нутгийн иргэд улирлын шинж чанартай ажил эрхлэх, барилгын засварын ажил эрхлэх, гар дээрээс наймаа эрхлэх, тодорхой богино хугацаагаар хот хооронд таксинд явах гэх мэт эсвэл бүр сумын төв орж, цалин хөлстэй ажилд эрхлэх, түргэн үйлчилгээний цэг, хүнсий дэлгүүр ажиллуулах гэх мэт үйл ажиллагааг оруулж болно.


Мөн, мал маллах үйл ажиллагаа нь цалин хөлсгүй хэдий ч шаардлагатай тохиолдолд малчид зах зээлд мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулах замаар мөнгөн орлого олох боломжтой тул орлого олох үйл ажиллагаанд хамруулж болно. Малчид малаа өсгөх, хариулах үед тухайн үйл ажиллагаа нь шууд цалин хөлс авчиргахгүй үйл ажиллагаа байх боловч малаа эсвэл мал аж ахуйгаас гаралтай түүхий эдийг зах зээлд борлуулсан нөхцөлд мөнгөн орлого олно. Иймээс, малчдын мал маллах үйл ажиллагааг цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэлт гэж авч үзлээ.

Харин гэрийн ажил хийх, хүүхдээ асрах, өндөр настай эцэг, эхээ болон гэр бүлийн гишүүнийг асрах, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болон өрхийн хүнд өвчтэй аль нэг гишүүнийг асрах ажиллагаа нь өрхийн мөнгөн орлогыг шууд өсгөх боломжгүй юм. Үлгэрлэвэл, тухайн өрхийн өвчтэй гишүүнийг асарсан үйлчилгээг шууд зах зээл рүү борлуулж мөнгөн орлого болгон хувиргах боломжгүй гэсэн үг юм. Гэсэн хэдий ч эдгээр гэрийн ажил, асаргаа зэрэг үнэлгээгүй ажил нь өрх гэрт зайлшгүй хийх шаардлагатай, өрхийн дотоод үйлчилгээ юм. Эдгээр үйл ажиллагаа нь өрхөд зайлшгүй хэрэгцээтэй байдаг ч гэсэн үнэлгээгүй хөдөлмөр эрхлэлт бөгөөд зах зээлийн эдийн засгийн онол, аргазүйд өрхийн дотоод үйлчилгээг зах зээлжүүлж, бүртгэж, үнэлж авч үздэггүй тул үндэсний тооцооны системээс ихэвчлэн гадна үлддэг. Өрхийн эдгээр дотоод үйлчилгээ нь зах зээлийн харилцаанд ихэвчлэн ороогүй байдаг тул зах зээлийн үнэлгээ огт байдаггүй. Энэхүү судалгаагаар албан бус хөдөлмөр эрхлэлт нь үндэсний тооцооны системийн ажиглагдаагүй, албан бус салбарын хэв шинжтэй илүү төстэй (UNSD, 2008). Бид энэхүү судалгаандаа дээрх онуудын цаг ашиглалтын судалгааны үндсэн өгөгдөл дээр тулгуурлан, хөдөө орон нутаг дах үнэлгээгүй хөдөлмөрт зарцуулах хугацаа ямар байгааг тодруулахыг зорилоо.

Дараагийн ангилалд, өөрийгөө асрахуй буюу, биеэ угаах, унтах, амрах хэвтэх гэх мэтээр өөрийгөө асрах үйл ажиллагаанд зарцуулах цаг, болон зурагт үзэх, сошиалд өнгөрүүлэх, найз нөхөдтэйгээ уулзах гэх мэтээр өөртөө зарцуулах чөлөөт цаг орно. Сайн дурын үйл ажиллагаанд болон сурч боловсроход зарцуулах цагийг мөн тусад нь ялган авч үзэж, цаг ашиглалтын явцыг судалсан. Хүснэгт 2а- аас Хүснэгт 6б-д хөдөө орон нутгийн иргэд болон малчдын ажлын нэг өдөрт дундажаар зарцуулж байгаа хоногийн

1440 минут /24 цаг/-ын 7 ангилж хуваасан ба харин энгийн регрессийн загвараар өөртөө зарцуулах чөлөөт цаг, өөрийгөө асрахуй болон сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулах цагийг нэгтгэн шинжилсэн. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулах цагийг тусад нь салгаж зарцуулалтыг шинжлэхийн шалтгаан нь эдгээр цагийн зарцуулалт нь хөдөлмөрийн ур чадварыг өсгөх, нийгмийн гишүүдийн харилцаа холбоог сайжруулах гэх мэтээр бүтээлч үр өгөөжтэй цаг байх боломжтой үйл ажиллагаа юм.

Энэхүү судалгаагаар, хөдөө орон нутгийн иргэдийн тэр дундаа малчин өрхийн гишүүдийн хөдөлмөрийн нийлүүлэлтийг буюу цаг зарцуулалтын дундаж хугацааг дээрх ангиллуудаар бүсээр, малчин, малчин бус өрхөөр болон хүйсээр ялган тооцож, цаг зарцуулалтанд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судалж үзлээ. Асрахуйн үйл ажиллагааг судлаачид шууд болон шууд бус гэж ангилж үздэг (Folbre, 2006) ч гэсэн энэхүү судалгаанд асрахуйг ийм байдлаар ангилж үзээгүй.



Зураг 1. Малчин өрхийн цалин хөлсгүй ажил ба үнэлгээгүй ажилд зарцуулах хугацааны дүрслэл

Судалгааны логик хүрээний дагуу тодорхойлогдсон малчин өрхийн цагийн хуваарилалтанд үзүүлэх хүчин зүйлийн шинжилгээг хийхдээ энгийн регрессийн аргыг ашигласан. Энгийн регрессийн загвар нь энгийн ойлгомжтой, тайлбарлахад хялбар ч хувьсагчдын хооронд шугаман хамаарал шаарддаг, тайлбарлах чадвар нь хязгаарлагдмал

зэрэг сул талтай. Ялангуяа энгийн регрессийн загвар нь эндогени (endogeneity)-ийн асуудлаас болж загварын үнэлгээ нь нийцгүй, алдаатай байх магадлалтай байдаг. Гэсэн хэдий ч энгийн регресс нь бидэнд хувьсагч хоорондын шугаман хамаарлыг шалгах замаар тухайн хамаарах хувьсагчид ямар үзүүлэлт илүү нөлөөлж байгаа талаар тодорхой үнэлгээ өгөх эхний алхам болж өгдөг билээ. Манай загварын хамаарах хувьсагчид нь малчин өрхийн тухайн төрлийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа ба үл хамаарах хувьсагчид тухайн хувьсагчид нөлөөлж болох хувь хүний шинж чанар, боловсрол, өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, газарзүйн байршил, бүсийн дамми, хугацааны хувьсагч гэх мэт бусад хувьсагчдыг бид загвартаа тусган үзлээ. Үүнд хамаарах хувьсагчдыг Зураг 1-д дүрсэлсний дагуу дараах 5 ангилалд салгаж авч үзлээ. Үүнд: 1. цалин хөлс болон бусад орлого олох үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа, 2. Мал маллах болон түүнтэй хамааралтай үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа, 3. Гэрийн ажилд зарцуулж буй дундаж хугацаа, 4. Асрахуйн ажилд зарцуулж буй дундаж хугацаа, 5. Бусад үйл ажиллагаанд зарцуулах дундаж хугацаа. Үүнд: сайн дурын, боловсролын үйл ажиллагаа, чөлөөт цаг болон өөрийгөө асрахуйд зарцуулж байгаа дундаж хугацааны нийлбэрээр авсан болно.

Судалгааны эмпирик аргагүй:

Судалгааны логик хүрээний дагуу тодорхойлогдсон малчин өрхийн цагийн хуваарилалтанд үзүүлэх хүчин зүйлийн шинжилгээг хийхдээ энгийн регрессийн аргыг ашиглалаа. Энгийн регрессийн загвар нь энгийн ойлгомжтой, тайлбарлахад хялбар ч хувьсагчдын хооронд шугаман хамаарал шаарддаг, тайлбарлах чадвар нь хязгаарлагдмал зэрэг сул талтай. Ялангуяа энгийн регрессийн загвар нь эндогени (endogeneity)-ийн асуудлаас болж загварын үнэлгээ нь нийцгүй, алдаатай байх магадлалтай байдаг. Гэсэн хэдий ч энгийн регресс нь бидэнд хувьсагч хоорондын шугаман хамаарлыг шалгах замаар тухайн хамаарах хувьсагчид ямар үзүүлэлт илүү нөлөөлж байгаа талаар тодорхой үнэлгээ өгөх эхний алхам болж өгдөг билээ. Манай загварын хамаарах хувьсагчид нь малчин өрхийн тухайн төрлийн үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа ба үл хамаарах хувьсагчид тухайн хувьсагчид нөлөөлж болох хувь хүний шинж чанар, боловсрол, өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт, газарзүйн байршил, бүсийн дамми, хугацааны хувьсагч гэх мэт бусад хувьсагчдыг бид загвартаа тусган үзлээ. Үүнд хамаарах хувьсагчдыг Зураг 1-д дүрсэлсний дагуу дараах 5 ангилалд салгаж авч үзлээ. Үүнд: 1. цалин хөлс болон бусад орлого олох үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа, 2. Мал маллах болон түүнтэй хамааралтай үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа, 3. Гэрийн ажилд зарцуулж буй дундаж хугацаа, 4. Асрахуйн ажилд зарцуулж буй дундаж хугацаа, 5. Бусад үйл ажиллагаанд зарцуулах дундаж хугацаа. Үүнд: сайн дурын, боловсролын үйл ажиллагаа, чөлөөт цаг болон өөрийгөө асрахуйд зарцуулж байгаа дундаж хугацааны нийлбэрээр авсан болно.

Дээрх 5 хамаарах хувьсагч бүрд хамаарах үл хамаарах хүчин зүйлсийг дараах (1)-(5) тэгшитгэлүүдээр харууллаа.

$$\begin{aligned}
ave_{paid_i} = & \beta_1 + \sum_{\delta=1}^{\delta-1} \delta_i edu_{\delta i} + \sum_{\alpha=1}^{\alpha-1} \theta_{\alpha} year_{\alpha i} + \beta_6 rural_i + \beta_7 livestock_i \\
& + \sum_{\mu=1}^{\mu-1} z_{\mu} season_{\mu i} + \beta_8 dependency_i + \beta_9 female_i \\
& + \sum_{\gamma=1}^{\gamma-1} k_{\gamma} region_{\gamma i} + \varepsilon_i
\end{aligned} \tag{1}$$

$$\begin{aligned}
ave_herd_i = & \beta_1 + \sum_{\delta=1}^{\delta-1} \delta_i edu_{\delta i} + \sum_{\alpha=1}^{\alpha-1} \theta_{\alpha} year_{\alpha i} + \beta_6 ageover5_i + \beta_7 rural_i \\
& + \beta_8 livestock_i + \sum_{\mu=1}^{\mu-1} z_{\mu} season_{\mu i} + \beta_9 dependency_i + \beta_{10} female_i \\
& + \sum_{\gamma=1}^{\gamma-1} k_{\gamma} region + \varepsilon_i
\end{aligned} \tag{2}$$

$$\begin{aligned}
ave_housework_i = & \beta_1 + \sum_{\delta=1}^{\delta-1} \delta_i edu_{\delta i} + \sum_{\alpha=1}^{\alpha-1} \theta_{\alpha} year_{\alpha i} + \beta_6 ageover14_i \\
& + \beta_7 below2_i + \beta_8 solar_i + \beta_9 dung_i + \beta_{10} wlfetch_i + \beta_{11} wash_machine_i \\
& + \beta_{12} electricity_i + \beta_{13} rural_i + \beta_{14} livestock_i + \sum_{\mu=1}^{\mu-1} z_{\mu} season_{\mu i} \\
& + \beta_{16} female_i + \sum_{\gamma=1}^{\gamma-1} k_{\gamma} region_{\gamma i} + \varepsilon_i
\end{aligned} \tag{3}$$

$$\begin{aligned}
ave_care_i = & \beta_1 + \sum_{\delta=1}^{\delta-1} \delta_i edu_{\delta i} + \sum_{\alpha=1}^{\alpha-1} \theta_{\alpha} year_{\alpha i} + \beta_6 below2_i \\
& + \beta_7 age2and6_i + \beta_8 ageover75_i + \beta_9 ageover60_i + \beta_{10} disabled_i \\
& + \beta_{13} rural_i + \beta_{14} livestock_i + \sum_{\mu=1}^{\mu-1} z_{\mu} season_{\mu i} + \beta_{15} female_i \\
& + \sum_{\gamma=1}^{\gamma-1} k_{\gamma} region_{\gamma i} + \varepsilon_i
\end{aligned} \tag{4}$$

$$\begin{aligned}
ave_others_i = & \beta_1 + \sum_{\delta=1}^{\delta-1} \delta_i edu_{\delta_i} + \sum_{\alpha=1}^{\alpha-1} \theta_{\alpha} year_{\alpha i} \\
& + \beta_8 solar_i + \beta_9 dung_i + \beta_{10} wlfetch_i + \beta_{11} wash_machine_i + \beta_{12} electricity_i \\
& + \beta_{13} rural_i + \beta_{14} livestock_i + \sum_{\mu=1}^{\mu-1} z_{\mu} season_{\mu i} + \beta_{16} female_i \\
& + \sum_{\gamma=1}^{\gamma-1} k_{\gamma} region_{\gamma i} + \varepsilon_i
\end{aligned} \tag{5}$$

Үүнд:

ave_paid_i- тухайн өрхийн гишүүний цалин хөлс болон бусад орлого олох үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа

ave_herd_i- тухайн өрхийн гишүүний мал маллах болон түүнтэй хамааралтай үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа

ave_housework_i- тухайн өрхийн гишүүний гэрийн ажилд зарцуулж буй дундаж хугацаа

ave_care_i- тухайн өрхийн гишүүний асрахуйн ажилд зарцуулж буй дундаж хугацаа

ave_others_i- тухайн өрхийн гишүүний сайн дурын, боловсролын үйл ажиллагаа, чөлөөт цаг болон өөрийгөө асрахуйд зарцуулж байгаа дундаж хугацааны нийлбэрээр авсан болно. Ингээд бусад үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа

edu_{\delta_i}-боловсролын дамми хувьсагч бөгөөд боловсролгүй, бага боловсролтой, ахлах дунд боловсролтойг харуулсан хувьсагч бөгөөд дээд боловсролтой нь жишиг хувьсагч болсон.

year_{\alpha i}- жилийн дамми хувьсагч бөгөөд 2011, 2015 оны хувьсагчид бөгөөд жишиг хувьсагч нь 2019 оны хувьсагч болсон.

rural_i-хөдөө малчин өрх байвал 1 сумын төв бол 0

livestock_i-малтай бол 1 үгүй бол 0

season_{\mu i} –улирлын дамми хувьсагч, хавар, зун, намрыг илтгэсэн хувьсагч. Үүнд өвлийн хувьсагч жишиг хувьсагч болсон.

dependency_i- Хамаарлын харьцаа буюу тухайн өрхийн нийт насанд хүрсэн хүний тухайн өрхийн нийт гишүүдэд харьцуулсан харьцаа

disabled_i- тухайн өрхөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг бол 1 үгүй бол 0

below2_i- тухайн өрхийн 2 ба түүнээс доош настай хүүхдийн тоо

age2and6_i-тухайн өрхийн 2-6 насны хүүхдийн тоо

ageover5_i- тухайн өрхийн 5 ба түүнээс дээш настай гишүүдийн тоо

ageover14_i- тухайн өрхийн 14 ба түүнөөс дээш настай гишүүдийн тоо

ageover60_i- тухайн өрхөд байгаа 60 ба түүнээс дээш настай гишүүний тоо

ageover75_i- тухайн өрхөд 75 ба түүнээс дээш настай гишүүн байгаа бол 1, үгүй бол 0

solar_i-нарны панель ашигладаг бол 1 үгүй бол 0.

dung_i- аргал түүдэг бол 1 үгүй бол 0

wlfetch_i- усаа явган зөөвөрлөдөг бол 1 үгүй бол 0

wash_machine_i- угаалгын машинтай бол 1 үгүй бол 0

female_i- эмэгтэй бол 1 үгүй бол 0

electricity_i- цахилгаан төвийн шугамтай холбогдсон бол 1 үгүй бол 0

region_i- баруун бүс, зүүн бүс, төвийн бүс болон хангайн бүсийн дамми хувьсагч.

Үүнд төвийн бүс жишиг болсон.

Тэгшитгэл (1)-ийн хувьд ажлын нэг өдөрт цалин хөлстэй ажилд зарцуулах дундаж хугацаанд тухайн хүний боловсролын түвшин, цаг хугацааны хувьсагч, байршил, малтай эсэх, өрхийн тэжээх ам бүлийн тоо, улирлын нөлөө болон хүйсийн нөлөө, бүсийн нөлөөг хамаарна гэж үзэж үл хамаарах хувьсагчдыг тус тус харуулсан байна.

Тэгшитгэл (2)-ийн хувьд мал маллах болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд ажлын нэг өдөрт зарцуулах хугацаанд нөлөөлөх хүчин зүйлсэд тухайн хүний боловсролын түвшин, цаг хугацааны хувьсагч, байршил, малтай эсэх, өрхийн тэжээх ам бүлийн тоо, тухайн өрхийн 5 ба түүнээс дээш настай гишүүний тоо, улирлын нөлөө болон хүйсийн нөлөө, бүсийн нөлөөг хамаарна гэж үзэж үл хамаарах хувьсагчдыг тус тус харуулсан байна. Үүнд 5 ба түүнээс дээш настай хүүхдийн хувьд тугал татах, ишиг хурга хариулах, аргал түүх гэх мэт үйл ажиллагаанд оролцдог үндэсний онцлогийг харгалзан энэхүү хувьсагчдыг нэмж авч үзлээ.

Тэгшитгэл (3)-ийн гэрийн ажилд ажлын нэг өдөрт зарцуулах дундаж хугацаанд тухайн хүний боловсролын түвшин, цаг хугацааны хувьсагч, байршил, малтай эсэх, тухайн өрхийн 2 ба түүнээс доош настай хүүхдийн тоо, 14 ба түүнээс дээш настай өрхийн гишүүний тоо, усаа явган зөөдөг эсэх, угаалгын машинтай эсэх, аргал түүдэг эсэх, нарны панелиар тогоо авдаг эсэх, мөн цахилгаан төвийн шугамтай эсэх, улирлын нөлөө болон хүйсийн нөлөө, бүсийн нөлөөг хамаарна гэж үзэж үл хамаарах хувьсагчдыг тус тус харуулсан байна. Эдгээр хувьсагчдын хүрээнд гэрийн ажилд зарцуулах хугацаанд тодорхой түвшинд нөлөө үзүүлнэ гэж төсөөлж орууллаа. Тухайлбал, усаа явган зөөх нь гэрийн ажилд зарцуулах цагийг өсгөнө, өрхийн 14 ба түүнээс дээш насны хүүхдүүд эцэг эхдээ гэрийн ажилд нь тусалдаг, аргал түүдэг бол мөн гэрийн ажилд зарцуулах цагийг ихэсгэх нөлөөтэй гэж үзсэн бол угаалгын машин нь гэрийн ажилд зарцуулах цагийг хэмнэх, мөн төвийн цахилгаан шугамтай нөхцөлд гэрийн ажилд илүү дэмтэй байх магадлалтай гэж үзлээ.

Тэгшитгэл (4)-ийн асрахуйн ажилд ажлын нэг өдөрт зарцуулах дундаж хугацаанд тухайн хүний боловсролын түвшин, цаг хугацааны хувьсагч, байршил, малтай эсэх, бага насны хүүхдийн тоо, цэцэрлэгийн насны буюу 2-6 хүртэл насны хүүхдийн тоо, өрхөд асаргаа шаардсан өвчтэй гишүүн байгаа эсэх, 60 ба түүнээс дээш болон 75 ба түүнээс дээш өрхийн гишүүдийн тоо, улирлын нөлөө болон хүйсийн нөлөө, бүсийн нөлөөг хамаарна гэж үзэж үл хамаарах хувьсагчдыг тус тус харуулсан байна.

Тэгшитгэл (5)-ийн бусад үйл ажиллагаанд ажлын нэг өдөрт зарцуулах дундаж хугацаанд тухайн хүний боловсролын түвшин, цаг хугацааны хувьсагч, байршил, малтай эсэх, усаа явган зөөдөг эсэх, угаалгын машинтай эсэх, аргал түүдэг эсэх, нарны панелиар тогоо авдаг эсэх, мөн цахилгаан төвийн шугамтай эсэх, улирлын нөлөө болон хүйсийн нөлөө, бүсийн нөлөөг хамаарна гэж үзэж үл хамаарах хувьсагчдыг тус тус харуулсан байна. Эдгээр хувьсагчдын хүрээнд бусад үйл ажиллагаанд зарцуулах хугацаанд тодорхой түвшинд нөлөө үзүүлнэ гэж төсөөлж орууллаа. Тухайлбал, усаа явган зөөх нь гэрийн ажилд зарцуулах цагийг өсгөх тул бусад үйл ажиллагаанд зарцуулах цагийг багасгах, аргал түүдэг, угаалгын машин нь хөдөлмөр хөнгөвчилөх тул бусад цагийг өсгөх, мөн төвийн цахилгаан шугамтай нөхцөлд бусад үйл ажиллагаанд зарцуулах цагийг илүү өсгөх магадлалтай гэж үзлээ.

Хөдөө орон нутгийн иргэд болон малчдын цаг ашиглалтын өнөөгийн байдал

Малын бэлчээртээ ойр буюу хээр хөдөөдөө өөрийн орон гэрээ барьж, малаа маллаж амьдардаг учраас малчдын ажил хөдөлмөрийг албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжтэй болгодог. Албан бус хөдөлмөрийн нэг онцлог нь өрхийн үйлдвэрлэлд голдуу суурилдаг бөгөөд цалин хөлсгүй ажил эрхлэлт байдаг. Албан бус цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг судлахын тулд малчид нэг өдрийг ямар ямар үйл ажиллагаанд, ямар хугацаа зарцуулж хийж байна вэ гэдгийг тодруулахын тулд цаг ашиглалтын анхан шатны өгөгдөл дээр суурилах шаардлага үүсч байна. Товчоор хэлбэл, малчин өрхийн цалин хөлсгүй хөдөлмөр болон үнэлгээгүй гэрийн ажилд зарцуулах хугацааг шинжлэхийн тулд 2011, 2015 болон 2019 оны цаг ашиглалтын түүвэр судалгааны (цаашид ЦАС гэх) өгөгдлийг ашиглалаа. Учир нь, цаг ашиглалтын судалгаа нь хүйсийн хувьд цаг ашиглалтын ялгаатай байдлыг сайтар гаргаж ирдэг (Seymour, Malapit, & Quisumbing, 2020) бөгөөд манай улсын хөдөө орон нутгийн мал аж ахуйн албан бус салбарт явагдаж байгаа цалин хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн цагийн зарцуулалт нь малчдын хүйсийн хувьд ямар ялгаатайг байгааг олж мэдэхэд чухал үүрэгтэй. Энэхүү түүвэр судалгаа нь манай улсын 5 бүсийн айл өрхийг түүвэрлэн авч, 24 цагийн туршид хийсэн ажил, үйл ажиллагаа тус бүрийг нэг бүрчлэн тэмдэглэж, тэмдэглэл хөтлүүлдэг бөгөөд нэг өрх долоо хоногийн 2 өдрийн туршид хийсэн ажил, үйл ажиллагааны бүрэн хэмжээний өгөгдлөөс бүрддэг. Энэхүү түүвэр судалгаанд, малчин өрхийг болон сумын төвийн айл өрхийг ч гэсэн хамруулсан болно. Мөн өрхийн гишүүдийн хувийн мэдээлэл, өрхийн гишүүний хэн болох зэрэг мэдээллийг тусгасан байдаг тул энэхүү түүвэр судалгаанаас өрхийн гишүүд ямар ямар үйл ажиллагааг бүтэн өдрийн турш хийж байгааг олж мэдэх боломжтой. Эдгээр 24 цагийн туршид хийсэн үйл ажиллагааг бид 7 ангилж үзсэн. Үүнд: 1. Цалин хөлстэй болон төлбөртэй үйл ажиллагаа, 2. Мал маллах болон малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулахтай холбоотой үйл ажиллагаа, 3. Гэрийн ажил, 4. Асрахуйн үйл ажиллагаа, 5. Сайн дурын болон суралцахуйн үйл ажиллагаа, 6. Чөлөөт цаг, 7. Өөрийгөө асрах үйл ажиллагаа орно. Ангилал тус бүрд ямар ямар үйл ажиллагааг оруулсан талаар мөн авч үзнэ. Хүснэгт 1-д түүвэрт хамрагдсан хөдөө орон

нутгийн иргэд, малчдын хамрагдалтын байдлыг харуулсан байна.

Хүснэгт 1. Өрхийн түүврийн хэмжээ 2011, 2015 болон 2019 оноор

Ангилал	2011	2015	2019
ЦАС-д хамрагдсан, орон нутгийн нийт өрхийн тоо	1650	1922	1953
Хөдөөний буюу малчин өрх	1068	953	1167
Сумын төвийн өрх	582	969	786
Бүсийн хувьд			
<i>Баруун бүс</i>	458	440	480
Хөдөөний буюу малчин өрх	345	233	306
Сумын төвийн өрх	113	207	174
<i>Хангайн бүс</i>	625	557	576
Хөдөөний буюу малчин өрх	430	359	403
Сумын төвийн өрх	195	198	173
<i>Төвийн бүс</i>	304	588	557
Хөдөөний буюу малчин өрх	145	221	298
Сумын төвийн өрх	159	367	259
<i>Зүүн бүс</i>	263	337	340
Хөдөөний буюу малчин өрх	148	140	160
Сумын төвийн өрх	115	197	180

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ны өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

ЦАС-г 2011, 2015, 2019 оны 3, 6, 9 болон 12 дугаар сард тус тус авсан байна. Иймээс, улирал бүрийн хувьд өөр өөр ажил хөдөлмөрийг хийж гүйцэтгэдэг малчдын хөдөлмөрийн онцлогийг тусгасан гэж үзэж болохоор байна. Улирлаас хамаарч ялгаатай байдаг мал аж ахуйн үйл ажиллагааны зарим жишээнд хаврын улиралд мал төллүүлэх, зуны улиралд сүү саах, цагаан идээ боловсруулах, айраг хийх, намрын улиралд хадлан тэжээл авах, өвлийн улиралд идэш хоолоо бэлтгэх зэрэг үйл ажиллагаа орно.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн гол онцлог нь малчин өрх бэлчээртээ ойр амьдарч, малаа малладаг бол сургууль, цэцэрлэг, банк, төрийн үйлчилгээ, дэлгүүр, эрүүл мэндийн төв зэрэг үйлчилгээ нь сумын төвд байдаг. Малчид хэрэгцээт үйлчилгээгээ авахын тулд бэлчээрээс сумын төв рүү зорчих шаардлагатай болдог. Бэлчээр буюу хөдөө нутагтаа малчид малаа маллах бөгөөд бэлчээрийн хэв шинж, хэрэглээний онцлогоос хамаарч хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөөний бэлчээртэй байна. Амьдрах гэрийнхээ ойр орчимд буюу зураг 2-т харуулсанчлан мал аж ахуйн цалин хөлсгүй хөдөлмөрийг эрхэлдэг. Сумын төв хүртэл малчид дундажаар 5-40 км зорчих шаардлагатай байдаг бөгөөд энэхүү зорчих зай нь өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаанаас хамаарч хэлбэлзэнэ. Бэлчээрийн хуваарилалт нь малчдын хувьд албан бус харилцаагаар зохицуулагдаж байдаг бөгөөд энэхүү хуваарилалт нь малчдын албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг хүчтэй тодорхойлдог. Бэлчээр гэдэг нь малчин өрхийн малын тэжээл, хүнс бөгөөд бэлчээр нь өрх бүрд албан бусаар хуваарилагддаг. Өөрөөр хэлбэл, ямар ч хоёр малчин айлын бэлчээр тус тусдаа байх хандлагатай бөгөөд хонь, ямаан сүргийг малчин өрхийн гишүүн тодорхой хөдөлмөр цагийг зарцуулж, өөрсдийн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны бэлчээрт бусдын мал сүргээс тусад нь дагаж хариулах шаардлагатай

байдаг. Энэхүү судалгааны хүрээнд бэлчээрийн хуваарилалтын зарчмыг гүнзгийрүүлэн авч үзэхгүй ч гэсэн бэлчээр хуваарилалтын уламжлалт зарчим нь мал аж ахуйг албан бус хөдөлмөр эрхлэлт болгох гол хүчин зүйл болж байгааг тэмдэглэж байна. Бэлчээрт малчин өрх байрлаж амьдрах нь малын хүнс тэжээлдээ ойр байх үндсэн шаардлагыг хангаж байгаа ч энэ нь өөрөө салбарыг албан бус болгож байна. Бэлчээрт малчин өрх ганц гэрээрээ эсвэл өөрийн хамаатнууд буюу аав, хүү, хүргэн, ах дүү гэх мэтээр нэгдэн амьдарч, тухайн бэлчээрийг эзэмшиж малаа хариулдаг тул мал аж ахуйн салбар бэлчээрийн хувьд тархай, зах зээлийн хувьд алслагдсан байдаг. Иймд малчин өрх нь үйлдвэрлэгч бас хэрэглэгчийн хэв шинжийн аль алиныг агуулж байдаг. Малчид мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулахын тулд ойролцоох сум эсвэл аймаг, хот руу зорчиж, зах зээлийн үнээр борлуулж болно. Гэхдээ энэ нь зардал өндөр, цаг ихээр зарцуулах, мөн мал сүргээ эзэнгүй орхих эрсдэлийг дагуулдаг тул тээврийн болон бусад зардлыг өсгөж байдаг. Мөн хот суурин газрын хөдөө аж ахуйн түүхий эдийн бөөний борлуулагчид өөрсдөө хөдөө орон нутгаар очиж, малчдаас түүхий эдийг худалдан авдаг. Орон нутгийн бэлчээр дэх үнэ болон зах зээлийн үнийн хооронд тээвэрлэлтийн болон бусад зардлын зөрүү өндөр байх нь элбэг. ЦАС-д тухайн үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлтэнд зарцуулах цагийг тухайн үйл ажиллагаанд зарцуулах цагт оруулан тооцдог. Тухайлбал, мал маллах болон малаа борлуулахтай холбоотой тээвэрлэлтийн цагийг мал маллах үйл ажиллагааны цагт нэгтгэн тооцсон гэсэн үг болно.



Зураг 2. Зун цагийн малчин өрхийн мал маллах үйл ажиллагаа

Хүснэгт 2–т ЦАС-нд хамрагдсан орон нутгийн иргэдийн түүврийн хэмжээг он оноор

харуулав. Энэхүү судалгаанд ЦАС-ны өгөгдлийг ашиглахдаа, малчид нь цалин хөлсгүй хөдөлмөр эрхэлж байгаа ч гэсэн амралтын болон ажлын өдрүүд тэдний цаг ашиглалтанд нөлөөлнө гэж үзлээ. Учир нь хэдийгээр малчид цалин хөлсгүй албан бус хөдөлмөр эрхэлж байгаа хэдий ч амралтын өдрүүдээр сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн хувцас хунарыг угааж цэвэрлэх, хүүхдүүдээ сумын төв рүү хүргэж өгөх, ажлын өдрүүдээр сумын төв орж ямар нэгэн ажил хөөцөлдөх зэргээр ажлын болон амралтын өдрүүд малчдын цагийн хуваарилалтанд нөлөө үзүүлэх тул амралтын болон ажлын өдрийг тусад нь салгасан. Энэхүү судалгаанд ашигласан ЦАС-ны өгөгдлийг ажлын өдрүүдэд зарцуулсан минутаар нь тооцож үзлээ.

Хүснэгт 2. 2011, 2015 болон 2019 оны ЦАС-д хамрагдан орон нутгийн иргэдийн тоо

	2011			2015			2019		
	нийт	эр	эм	нийт	эр	эм	нийт	Эр	Эм
Нийт түүвэр	3047	1466	1581	3039	1528	1511	2722	1281	1441
малчин	2036	1015	1021	1600	812	788	1732	879	853
Сумын төвийн иргэн	1011	451	560	1439	716	723	990	402	588
Баруун бүс	898	443	455	708	337	371	764	367	397
малчин	673	332	341	383	190	193	510	254	256
Сумын төвийн иргэн	225	111	114	325	147	178	254	113	141
Хангайн бүс	1111	511	600	992	533	459	708	311	397
малчин	789	376	413	669	345	324	508	240	268
Сумын төвийн иргэн	322	135	187	323	188	135	200	71	129
Төвийн бүс	579	238	280	850	390	460	852	420	432
малчин	267	136	131	328	163	165	505	270	235
Сумын төвийн иргэн	251	102	149	522	227	295	347	150	197
Зүүн бүс	520	274	246	489	268	221	398	183	215
малчин	307	171	136	220	114	106	209	115	94
Сумын төвийн иргэн	213	103	110	269	154	115	189	68	121

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ны өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

ЦАС-ны судалгаанд оролцогчдын гуравны хоёр нь хоёр өдрийн буюу 48 цагийн туршид хийсэн үйл ажиллагаагаа тэмдэглэн мэдээлсэн бол гуравны нэг нь гурван өдрийн буюу 72 цагийн туршид хийсэн үйл ажиллагаагаа тэмдэглэж мэдээлсэн байна. Энэхүү судалгаанд 18 ба түүнээс дээш насны хүмүүсийн ажлын өдрүүдээр тэмдэглэсэн үйл ажиллагааны минутыг зарцуулсан өдөрт нь хувааж дундажыг нь гаргасан бөгөөд энэхүү дундаж утгыг энэхүү судалгаанд ашиглалаа. Ингээд ажлын өдрүүдэд тэмдэглэсэн ЦАС-ны мэдүүлсэн үйл ажиллагааны өгөгдлийг дээр тодорхойлсон 7 ангилалд хуваасан болно. Эдгээр ангилсан үйл ажиллагаа тус бүрийг дараах байдлаар тодруулж авч үзсэн. Үүнд:

1. Цалин хөлстэй үйл ажиллагаа. Энэхүү ангилалд цалин хөлстэй ажил, мал аж ахуйгаас бусад орлого олох үйл ажиллагаа, тухайлбал хүнсний дэлгүүр ажиллуулах, бараа зарах, улирлын чанартайгааг барилгын ажил хийх гэх мэт мөнгөн орлого олох зорилгоор хийгдэж байгаа үйл ажиллагаанд зарцуулсан хугацааг авч үзсэн.

2. Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа. Мал маллахтай холбоотой бүхий л үйл ажиллагаа, сүү, цагаан идээ боловсруулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулсан хугацааг авч үзсэн.
3. Гэрийн ажил. Гэр цэвэрлэх, хувцсаа угаах, хашаа хороогоо цэвэрлэх, хоол хийх, галаа түлэх гэх мэт гэрийн ажилд зарцуулсан хугацааг авч үзсэн.
4. Асрахуй. Хүүхэд, гэр бүлийн өвчтэй гишүүн, эсвэл хөгшдийг асрахад зарцуулсан хугацааг авч үзсэн.
5. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа. Сургалт семинарт суух, сайн дурын үйл ажиллагаанд оролцоход зарцуулсан хугацааг авч үзсэн.
6. Чөлөөт цагийн үйл ажиллагаа. Зурагт үзэх, радио сонсох, сошиалд зарцуулах зэрэг үйл ажиллагаанд зарцуулах хугацааг авч үзсэн.
7. Өөрийгөө асрахуй. Усанд орох, хоол цайгаа идэж, уух, унтах, амрах зэрэг хувийн үйл ажиллагаанд зарцуулсан хугацааг авч үзсэн.

Дээрх 7 төрлийн үйл ажиллагаа нь хүмүүсийн хүйсийн хувьд, бүс нутгийн хувьд ямар ялгаатай байна гэдгийг доорх хүснэгтүүдэд харууллаа. Мөн малчид болон сумын төвийн иргэдийн хувьд дээрх ангилал тус бүрт зарцуулж байгаа цаг хугацаа ямар ялгаатай байна вэ гэдгийг харууллаа.

Хүснэгт 3а. Баруун бүсийн малчдын зарцуулсан дундаж минут /ажлын 1 өдөр-18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Баруун бүс	эр	эр	эр	эм	эм	Эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	Дундаж Минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	36	79	90	43	80	81
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	491	536	445	246	285	209
3	Гэрийн ажил	88	56	71	342	292	309
4	Асрахуй	11	12	14	39	38	50
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	14	15	9	10	7	8
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	108	112	137	85	107	124
7	Өөрийгөө асрахуй	692	630	674	675	631	659

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ны өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

Хүснэгт 3а-д харуулснаар, баруун бүсийн эрэгтэй, эмэгтэй малчид цалин хөлстэй болон орлого олох үйл ажиллагаанд ойролцоо цаг зарцуулж байгаа нь харагдаж байна. 2019 оны орлого олох үйл ажиллагаанд зарцуулах дундаж хугацаа нь 2011 оны мэдээлэлтэй харьцуулахад, эрэгтэй малчдын хувьд 2.5 дахин, харин эмэгтэй малчдын

хувьд 1.8 дахин өсчээ. Мал маллахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулах цаг дээрх онуудын хувьд буурах хандлагатай байгаа бөгөөд нийтдээ эмэгтэй малчид эрэгтэйчүүдээс бараг 2 дахин бага хугацааг зарцуулж байна. Эсрэгээр, гэрийн ажилд эмэгтэйчүүд эрчүүдээс бараг 4-5 дахин илүү цагийг зарцуулж байна. Асрахуйн үйл ажиллагаанд зарцуулж байгаа цаг нийт дундажаар бага байгаа ч эмэгтэй малчид эрчүүдээс даруй 3-3.5 дахин их цагийг зарцуулжээ. Сайн дурын үйл ажиллагаа болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулах дундаж хугацаа 5 минутаас бага байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн хувьд буурах хандлагатай, эмэгтэйчүүдийн хувьд тогтмол бага байна. Чөлөөт цагийн үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа эрэгтэйчүүдийнх илүү байгаа нь харагдаж байна. Харин, өөрийгөө асрахуйн цаг эрэгтэйчүүдэд илүү их байгааг харж болно.

Хүснэгт 36. Баруун бүсийн сумын төвийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зарцуулсан дундаж хугацаа /ажлын 1 өдөр -18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Баруун бүс-сум	эр	Эр	эр	эм	Эм	Эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	Дундаж Минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	241	245	283	188	186	234
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	115	122	101	84	50	35
3	Гэрийн ажил	123	116	102	268	280	239
4	Асрахуй	21	24	38	47	74	70
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	24	22	14	15	16	14
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	204	239	217	156	173	177
7	Өөрийгөө асрахуй	712	672	685	682	661	671

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ын өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

36 хүснэгтэд харуулсанаар, баруун бүсийн сумын төвийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалин хөлстэй болон орлого олох үйл ажиллагаанд зарцуулж байгаа цаг малчдынхтай харьцуулахад 3-6 дахин өндөр байгаа ч дунджаар эрчүүдийн зарцуулсан хугацаа эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Сумын төвийнхөн мал маллах үйл ажиллагаанд харьцангуй бага цаг зарцуулж байгаа бөгөөд ялангуяа баруун бүсийн сумын төвийн эмэгтэйчүүд 1.3-2.2 дахин бага цагийг эрчүүдтэй харьцуулахад зарцуулж байна. Сумын төвийн эрчүүдийн мал маллахад зарцуулах цаг тогтвортой байгаа ч эмэгтэйчүүдийн хувьд мэдэгдэхүйц буурчээ. 2019 онд энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг бүгдийн хувьд буурсан байна. Баруун бүсийн эрчүүд гэрийн ажилд харьцангуй их хугацааг зарцуулж байгаа ч эмэгтэйчүүдийнхэй харьцуулахад 2.1-2.4 дахин бага цагийг гэрийн ажилд зарцуулж байна. Баруун бүсийн сумын төвийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гэрийн ажилд зарцуулах хугацаа дундажаараа буурсан байна. Харин асрахуйд зарцуулж байгаа цаг малчдынхаас өндөр байгаа ч сумын төвийн эмэгтэйчүүдийн асрахуйн цаг эрчүүдийнхээс даруй 1.8-3 дахин их байна. Сумын төвийн эрчүүдийн асрахуйд зарцуулж байгаа

хугацаа 2011 оныхоос 1.8 дахин өссөн байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн асрахуйд зарцуулах дундаж хугацаа ч гэсэн өссөн байна. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулах хугацаа малчдынхтай харьцуулахад өндөр байгаа боловч эрчүүдийнх 1.7 дахин буурсан, харин эмэгтэйчүүд тогтмол бага хугацааг зарцуулсан хэвээр байна. Чөлөөт цагийн үйл ажиллагаа эмэгтэй, эрэгтэй аль алины хувьд өсөх хандлагатай байгаа ч эрчүүд өдөрт дундажаар 40-66 минут илүү цагийг чөлөөт цаг байдлаар зарцуулж байгаа нь харагдлаа. Өөрийгөө асрахуйд зарцуулах хугацаа эрэгтэйчүүдийн хувьд илүү байгаа энэ нь дундажаар 10-30 минут байна.

Хүснэгт 4а. Хангайн бүсийн эрэгтэй, эмэгтэй малчдын зарцуулсан дундаж минут /ажлын 1 өдөр -18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Хангайн бүс-хөдөө	эр	эр	эр	эм	Эм	Эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	Дундаж Минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	23	44	45	34	43	66
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	446	524	489	312	324	300
3	Гэрийн ажил	105	42	98	265	260	231
4	Асрахуй	17	14	6	33	32	37
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	8	4	2	8	1	1
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	169	106	148	141	85	139
7	Өөрийгөө асрахуй	672	706	652	647	695	666

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ын өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

Хүснэгт 4а-д харуулсанаар, Хангайн бүсийн малчдын цалин хөлстэй үйл ажиллагаанд зарцуулах цаг өсөх хандлагатай байгаа бол эмэгтэй малчид цалин хөлстэй орлого олох үйл ажиллагаанд цагаа илүү зарцуулж байгаа нь харагдаж байна. Малчин эмэгтэйчүүд өдөрт дундажаар 1-11 минут илүү хугацааг цалин хөлстэй ажилд зарцуулж байна. Мал маллахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа малчин эрэгтэйчүүдийн хувьд 1.4-1.6 дахин илүү хугацааг эмэгтэйчүүдээс илүү зарцуулж байна. Хангайн бүсийн малчин эмэгтэйчүүд баруун бүсийн малчин эмэгтэйчүүдийг бодвол харьцангуй илүү их хугацааг мал маллахад зарцуулж байна. Хангайн бүсийн малчин эрчүүд гэрийн ажилд бүсийнхээ малчин эмэгтэйчүүдтэй харьцуулахад ойролцоогоор 2.3-6 дахин бага хугацааг зарцуулж байна. Гэрийн ажилд зарцуулах цаг эрэгтэй, эмэгтэй малчдын хувьд буурсан үзүүлэлттэй байна. Асрахуйд зарцуулж байгаа малчин эрчүүдийн дундаж хугацаа буурах хандлагатай байгаа бол малчин эмэгтэйчүүдийн зарцуулдаг хугацаа өсөх хандлагатай байна. Эмэгтэйчүүдийн асрахуйн хугацаа 1.9-6 дахин их байна. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулсан цаг маш бага байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн хувьд үүнд бараг цаг зарцуулдаггүй байна. Хангайн

бүсэд ч гэсэн чөлөөт цагийн үйл ажиллагаанд эрчүүдийн зарцуулж байгаа хугацаа өндөр байна. Эрчүүд өдөрт дундажаар 9-28 минутыг өөрийн чөлөөт цагт зарцуулж байна. Өөрийгөө асрахуйнд зарцуулах цаг ч гэсэн эрчүүдийн хувьд эмэгтэй малчдынхаас илүү байна ч 2019 оны хувьд эмэгтэйчүүдийнх 14 минутаар илүү болсон байна.

Хүснэгт 4б. Хангайн бүсийн сумын төвийн эрэгтэй, эмэгтэй иргэдийн зарцуулсан дундаж хугацаа /ажлын 1 өдөр -18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Хангайн бүс-сумын төв	эр	Эр	эр	Эм	Эм	Эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	Дундаж Минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	204	285	195	221	226	181
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	91	70	78	46	26	37
3	Гэрийн ажил	153	76	155	245	210	260
4	Асрахуй	20	38	35	48	53	37
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	8	2	1	14	12	2
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	244	167	274	169	143	224
7	Өөрийгөө асрахуй	720	802	703	697	770	699

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ын өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

Хүснэгт 4б-д үзүүлсэнээр, сумын төвийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд цалин хөлстэй үйл ажиллагаанд ойролцоо хугацааг зарцуулсан ч энэхүү хугацаа хоёр хүйсийн аль алины хувьд буурах хандлагатай байна. Ханган бүсийн сумын төвийн эмэгтэйчүүд 2011 онд 17 минут илүү зарцуулж байсан хэдий ч энэ үзүүлэлт 2015, 2019 оны хувьд буурсан байна. Мал маллахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулах хугацаа хоёр хүйсийн хувьд буурах хандлагатай байгаа бөгөөд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад ойролцоогоор 2 дахин бага хугацааг энэ үйл ажиллагаанд зарцуулж байна. Гэрийн ажлын хувьд, эрчүүд нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.6- 2.7 дахин бага хугацааг зарцуулж байна. Асрахуйн үйл ажиллагаанд зарцуулах дундаж цаг эмэгтэйчүүдийн хувьд хангайн бүсэд өндөр байгаа ч эрчүүдийн зарцуулах дундаж цаг хол зөрүүгүй байна. Харин 2011 оны хувьд эрчүүд асрахуйн ажилд даруй 2.4 дахин бага цагийг зарцуулж байсан байна. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулах дундаж хугацаа хоёр хүйсийн хувьд харьцангуй бага байгаа бөгөөд буурах хандлагатай ч эмэгтэйчүүд илүү их хугацааг энэхүү үйл ажиллагаанд зарцуулж байна. Чөлөөт цагийн үйл ажиллагаа болон өөрийгөө асрахуйн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй их хугацааг эрэгтэйчүүд дундажаар зарцуулсан байна. Үүнд 24-75 минутыг эрчүүд чөлөөт цагтаа илүү харин 4-32 минутыг өөрийгөө асрахуйд эмэгтэйчүүдээс илүү хугацааг тус тус илүү зарцуулсан байна.

Хүснэгт 5а. Төвийн бүсийн эрэгтэй эмэгтэй малчдын зарцуулсан дундаж минут /ажлын 1 өдөр -18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Төвийн бүс-хөдөө	эр	эр	эр	эм	эм	Эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	Дундаж минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	15	72	53	18	68	66
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	467	449	546	303	337	315
3	Гэрийн ажил	66	72	63	268	224	269
4	Асрахуй	7	13	11	48	33	39
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	5	0	2	1	0	6
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	144	139	136	95	110	122
7	Өөрийгөө асрахуй	736	695	629	707	668	623

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ын өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

Хүснэгт 5а-д харуулсанаар, төвийн бүсийн эрэгтэй, эмэгтэй малчдын цалин хөлстэй, орлого олох үйл ажиллагаанд зарцуулах хугацаа харьцангуй ойролцоо байгаа ч 2019 оны үзүүлэлтээр малчин эмэгтэйчүүд өдөрт 13 минут их хугацааг зарцуулж байна. Мал аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулж байгаа хугацаа нь эрэгтэй малчдын хувьд эмэгтэй малчдынхаас даруй 1.3-2 дахин их байна. Гэрийн ажлын хувьд, төвийн бүсийн малчин эрчүүд малчин эмэгтэйчүүдээс 3.1- 4.2 дахин бага хугацааг зарцуулж байна. Мөн, малчин эмэгтэйчүүдийн асрахуйд зарцуулж байгаа хугацаа нь эрчүүдийнхээс 2.5-6.8 дахин илүү байна. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулж байгаа хугацаа нь хүйс харгалзахгүйгээр бага байсан байна. Чөлөөт цаг болон өөрийгөө асрахуйн үйл ажиллагаанд төвийн бүсийн малчин эрчүүд малчин эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулдаг нь харагдлаа. Үүнд эрчүүд чөлөөт цагтаа 14-49 минут, өөрийгөө асрахуйд 6-29 минут өдөр дундажаар эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү зарцуулж байна.

Хүснэгт 5б. Төвийн бүсийн сумын төвийн эрэгтэй, эмэгтэй иргэдийн зарцуулсан дундаж хугацаа /ажлын 1 өдөр -18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Төвийн бүс - сумын төв	эр	эр	эр	эм	Эм	Эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	316	299	239	277	255	221
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	40	71	119	26	42	56
3	Гэрийн ажил	161	102	119	203	193	228
4	Асрахуй	23	27	50	53	57	62
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	26	6	6	28	16	8
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	212	210	204	173	172	176
7	Өөрийгөө асрахуй	662	725	703	680	705	689

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ын өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

Хүснэгт 5б-д үзүүлсэнээр, төвийн бүсийн цалин хөлстэй үйл ажиллагаанд сумын төвийн эрчүүд дундажаар өдөрт 18- 44 илүү минут зарцуулжээ. Гэхдээ л аль ч хүйсийн хүмүүсийн энэхүү үйл ажиллагаанд зарцуулах хугацаа буурах хандлагатай байна. Мөн мал маллахтай холбоотой үйл ажиллагаанд эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрчүүд 1.5-2.1 дахин илүү хугацаа зарцуулжээ. Гэрийн ажлын хувьд төвийн бүсийн сумын төвийн эрчүүд эмэгтэйчүүдийнхээс 1.2 -1.9 дахин бага хугацааг зарцуулж байгаа нь харагдлаа. Эмэгтэйчүүд нь эрчүүдийг бодвол 1.2-2.3 илүү их хугацааг асрахуйн үйл ажиллагаанд зарцуулж байна. Ялангуяа, 2011 болон 2015 онд эмэгтэйчүүдийн асрахуйн цаг эрчүүдийнхээс ойролцоогоор 2 дахин их байсан ч 2019 онд энэхүү зөрүү 1.2 дахин их болж буурчээ. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд зарцуулах хугацаа 2011 онд хоёр хүйсийн хувьд ойролцоо байсан ч сүүлийн хоёр онд эмэгтэйчүүд илүү их хугацааг энэхүү үйл ажиллагаанд зарцуулжээ. Чөлөөт цагийн болон өөрийгөө асрахуйн үйл ажиллагаанд төвийн бүсийн сумын төвийн эрчүүд эмэгтэйчүүдээс илүү их хугацааг зарцуулж байна. Үүнд эрчүүд өдөрт дундажаар чөлөөт цагтаа 28-39 минут, өөрийгөө асрахуйд 14-20 минут илүү тус тус зарцуулжээ.

Хүснэгт 6а. Зүүн бүсийн эрэгтэй эмэгтэй малчдын зарцуулсан дундаж минут /ажлын 1 өдөр-18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Зүүн бүс-хөдөө	эр	эр	эр	эм	Эм	Эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	43	83	36	26	76	34
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	432	396	467	265	258	284
3	Гэрийн ажил	73	71	81	297	240	293
4	Асрахуй	7	13	15	42	41	46
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	5	2	0	6	7	0
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	177	155	143	126	121	109
7	Өөрийгөө асрахуй	703	720	698	678	697	674

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ын өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

Хүснэгт 6а-д харуулснаар, зүүн бүсийн малчин эрэгтэйчүүд эмэгтэйчүүдтэй харьцуулахад цалин хөлстэй, орлого олох үйл ажиллагаанд өдөрт дундажаар 2-17 минут илүү зарцуулжээ. Мал маллахтай холбоотой үйл ажиллагааны хувьд малчин эрчүүд эмэгтэйчүүдээс өдөрт дундажаар 1.5-1.6 дахин илүү их цагийг зарцуулжээ. Харин, гэрийн ажил малчин эмэгтэйчүүд эрчүүдээс 3.3- 4 дахин илүү хугацааг, асрахуйд 3-6 дахин их хугацааг зарцуулжээ. Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаан хүйс үл хамааран бага хугацааг зарцуулсан байна. Чөлөөт цагийн болон өөрийгөө асрахуйн үйл ажиллагаанд зүүн бүсийн малчин эрчүүд бусад бүсийн нэгэн адил эмэгтэйчүүдээс 34-51 минут болон 23- 25 минутыг тус тус харгалзан илүү зарцуулжээ.

Хүснэгт 66. Зүүн бүсийн сумын төвийн эрэгтэй эмэгтэй иргэдийн зарцуулсан дундаж хугацаа /ажлын 1 өдөр -18 ба түүнээс дээш настай/

№	Үйл ажиллагаа	2011	2015	2019	2011	2015	2019
	Зүүн бүс- сумын төв	эр	эр	эр	Эм	Эм	эм
		дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут	дундаж минут
1	Цалин хөлстэй үйл ажиллагаа	137	271	291	164	262	236
2	Мал маллахтай холбоотой үйл ажиллагаа	162	93	71	76	38	45
3	Гэрийн ажил	139	86	131	271	221	246
4	Асрахуй	20	48	45	54	57	72
5	Сайн дурын болон боловсролын үйл ажиллагаа	27	16	7	12	15	4
6	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	244	199	215	168	161	174
7	Өөрийгөө асрахуй	711	727	680	695	686	663

Эх сурвалж: (ҮСХ, 2011, 2015, 2019)-ны ЦАС-ын өгөгдөл ашигласан судлаачдын тооцоо

Хүснэгт 66-д харуулсанаар, цалин хөлстэй үйл ажиллагаанд зүүн бүсийн сумын төвийн эрчүүд эмэгтэйчүүдийнхээс 2011 оноос бусад хугацаанд илүү их цаг зарцуулжээ. Эрчүүд дундажаар өдөрт 9-35 минут илүү хугацааг энэхүү үйл ажиллагаанд зарцуулжээ. Гэхдээ, хоёр хүйсийн аль алины хувьд цалин хөлстэй, орлого олох үйл ажиллагаанд зарцуулах хугацаа өсөж иржээ. Түүнчлэн, мал маллахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулах хугацаа нь зүүн бүсийн сумын төвийн иргэдийн хувьд багасах хандлагатай байна. Гэрийн ажилд зарцуулах хугацаа нь эмэгтэйчүүдийнх дундажаар 1.8-2.5 дахин илүү цагийг зарцуулж иржээ. Асрахуйн үйл ажиллагааны хувьд хоёр хүйсийн аль алины хувьд өсөх хандлагатай ч эмэгтэйчүүд нь 1.1-2.7 дахин илүү их хугацааг зарцуулж байна. Зүүн бүсийн сумын төвийнхөн сайн дурын болон боловсролын үйл ажиллагаанд харьцангуй их цагийг зарцуулж байгаа ч эмэгтэйчүүдийн цаг зарцуулалт эрчүүдийнхээс харьцангуй бага байна. Мөн, чөлөөт цаг болон өөрийгөө асрахуйн үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн зарцуулж байгаа хугацаа нь эмэгтэйчүүдийнхээс их байжээ. Үүнд чөлөөт цагт өдөрт дундажаар 38-76 минут, өөрийгөө асрахуйн цагт 16-41 минут тус тус эрчүүд илүү зарцуулжээ.

Ерөнхийдөө, цаг хугацааны ашиглалт нь хүйсийн хувьд ихээхэн ялгаатай байгааг ЦАС-ны гурван жилийн өгөгдөл харуулж байна. Мал аж ахуйн салбар нь бүхэлдээ албан бус, өрхийн үйлдвэрлэлд суурилсан хэв шинжтэй байдаг ч гэсэн өрх дотор нь задлаад үзэхэд хүйсийн хувьд ямар үйл ажиллагаанд илүү их цагаа зарцуулж, төрөлжиж байгааг харж болохоор байна. Тэр дундаа эмэгтэйчүүд нь үнэлгээгүй гэрийн ажил, асрахуйн ажилд илүү их хугацааг зарцуулж байгаа бол эрчүүд нь орлого олох боломжтой үйл ажиллагаа буюу мал аж ахуйн үйл ажиллагаанд илүү их хугацааг зарцуулж байгаа нь харагдаж байна.

ЦАС-ны өгөгдлийн шинжилгээ:

Энэхүү ЦАС-ны шинжилгээний дараагийн алхам болгон, үйл ажиллагаа тус бүрийн зарцуулалтын хугацаанд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн шинжилгээг энгийн ре-

грессийн шинжилгээгээр хийв. Цаг ашиглалтын дээрх ангилсан ангилалаар ангилал тус бүрийн үйл ажиллагааны зарцуулалтын дундаж хугацаанд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7. Энгийн регрессийн шинжилгээний хувьсагчдын тодорхойлогч статистик

Хувьсагчид	Ажиглал-тын тоо	Дундаж утга	Ст. хазайлт	Тайлбар
Ave paid	9006	126.7	222.8	Цалин хөлстэй болон орлого олох үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа
Ave herd	9006	255.9	268.9	Мал маллах болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа
Ave housew~k	9006	178.4	156.7	Гэрийн ажилд зарцуулж буй дундаж хугацаа
Ave_care	9006	34.4	78.9	Асрахуйн ажилд зарцуулж буй дундаж хугацаа
Ave others	9006	844.5	204.2	Сайн дурын, боловсролын, чөлөөт цаг болон өөрийгөө асрахад зарцуулж буй дундаж хугацаа
Uned	9006	0.08	0.27	Боловсролгүй
primary	9006	0.45	0.49	Суурь боловсролтой
highschool	9006	0.36	0.48	Ахлах сургуулийн боловсролтой
year11	9006	0.34	0.47	2011 оны дамми хувьсагч
year15	9006	0.34	0.47	2015 оны дамми хувьсагч
Ageover5	9006	3.2	1.4	5 дээш насны гэр бүлийн гишүүдийн тоо
Ageover14	9006	2.5	1.2	14 дээш настай гэр бүлийн гишүүдийн тоо
below2	9006	0.26	0.49	2 ба түүнээс доог насны гэр бүлийн гишүүний тоо
Age2an6	9006	0.32	0.56	2 ба 6 хүртэл насны гэр бүлийн гишүүний тоо
Ageover75	9006	0.02	0.14	75-аас дээш настай гэр бүлийн гишүүний тоо
Ageover60	9006	0.09	0.29	60-аас дээш настай гэр бүлийн гишүүний тоо
Disabled	9006	0.04	0.2	Хөгжлийн бэрхшээлтэй
Solar	9006	0.57	0.49	Нарны панельтай өрх
Dung	9006	0.82	0.39	Аргал түүдэг өрх
Wlkfetch	9006	0.54	0.49	Усаа явган зөөвөрлөж авдаг эсэх
wash_machine	9006	0.41	0.49	Угаалгын машинтай эсэх
Electricity	9006	0.46	0.49	Цахилгаантай эсэх
Rural	9006	0.59	0.49	Хөдөө
Livestock	9006	0.69	0.46	Малтай эсэх
Spring	9006	0.26	0.44	Хаврын улирлын дамми хувьсагч
Summer	9006	0.25	0.43	Зуны улирлын дамми хувьсагч
Autumn	9006	0.24	0.43	Намрын улирлын дамми хувьсагч
dependency	9006	0.54	0.28	Хамаарлын харьцаа буюу тухайн өрхийн нийт насанд хүрсэн хүний тухайн өрхийн нийт гишүүдэд харьцуулсан харьцаа
Female	9006	0.53	0.49	Хүйсийн дамми
West	9006	0.27	0.44	Баруун бүсийн дамми хувьсагч
East	9006	0.16	0.36	Зүүн бүсийн дамми хувьсагч
Central	9006	0.26	0.43	Төвийн бүсийн дамми хувьсагч
Khangai	9006	0.31	0.46	Хангайн бүсийн дамми хувьсагч

Хүснэгт 8. Энгийн регрессийн шинжилгээний үр дүн

Үл хамаарах хувьсагчид	Хамаарах хувьсагчид				
	Ave paid	Ave herd	Ave housew-k	Ave care	Ave others
	(1)	(2)	(3)	(4)	(5)
primary	13.0** (7.7)	7.0*** (7.9)	7.5 (5.2)	6.4** (2.9)	-23.4*** (7.6)
Highschool	77.8*** (8.0)	-16.8** (8.2)	1.3 (5.4)	5.5** (3.0)	-58.0*** (8.0)
Higher education	194.1*** (9.8)	-72.2*** (10.1)	-51.2*** (6.7)	9.8*** (3.7)	-78.9*** (9.9)
year11	11.0** (5.3)	-32.2*** (5.5)	10.5*** (3.7)	-6.2*** (1.9)	9.2** (5.4)
year15	9.1** (5.6)	-8.4 (5.9)	-20.9*** (3.5)	-4.9*** (1.9)	0.9 (5.1)
Ageover5		-1.3 (1.6)			
Ageover14			-7.0*** (1.2)		
below2			4.3** (2.8)	46.5*** (1.6)	
Age2an6				14.1*** (1.4)	
Ageover75				-0.9 (2.6)	
Ageover60				4.7** (2.7)	
Disabled				-1.7 (3.8)	
Solar			3.4 (5.1)		-44.8*** (7.4)
Dung			11.9*** (4.1)		10.9** (6.0)
Wlkfetch			-0.4 (3.0)		13.2*** (4.4)
wash_machine			-7.7** (3.8)		-21.3*** (5.6)
Electricity			14.1** (6.0)		59.2*** (8.9)
Rural	-119.2 *** (4.8)	249.8*** (5.0)	-10.2** (4.8)	-15.2*** (1.8)	-43.7*** (7.2)
Livestock	-63.4*** (5.2)	107.0*** (5.4)	7.9** (3.7)	-9.3*** (2.0)	-21.1*** (5.4)
Spring	42.1*** (5.9)	-4.3 (6.0)	-7.7** (4.0)	-2.9 (2.2)	-26.2*** (5.9)
Summer	59.1*** (5.9)	-54.4*** (6.1)	2.6 (4.0)	5.6** (2.2)	-12.8** (5.9)
Autumn	57.2*** (6.0)	-121.2*** (6.1)	22.7*** (4.0)	-1.0 (2.2)	34.3*** (6.0)
dependency	-71.9*** (8.5)	16.0 (10.6)			
Female	-23.2*** (4.1)	-128.8*** (4.2)	170.4*** (2.8)	24.7*** (1.6)	-47.2*** (4.1)
West	3.6 (6.4)	3.9 (6.9)	18.9*** (4.4)	-2.9 (2.4)	-34.2*** (6.5)
Khangai	-4.9 (6.3)	20.2*** (6.4)	-9.3** (4.3)	-3.0 (2.3)	-4.6*** (6.3)
Central	5.1 (6.5)	29.0*** (6.7)	-13.4*** (4.4)	-1.5 (2.5)	-16.3** (6.4)
Cons	391.4*** (11.9)	149.1*** (15.0)	92.9*** (9.9)	19.4*** (4.0)	954.2*** (14.2)

Үүнд: Стандарт алдааг хаалтанд харуулсан бөгөөд, ***, ** ба * тэмдэглээ нь харгалзан 1%, 5

ЦАС-ын өгөгдлийг ашиглан энгийн регрессийн загвараар өрхүүдийн дээр ангилсан үйл ажиллагааны цаг зарцуулалтад ямар хүчин зүйлс, хэр хэмжээнд нөлөөлж байгааг тооцож, үр дүнг хүснэгт 8-д үзүүлээ. Загварын хамаарах хувьсагчид ажлын нэг өдөрт хийж гүйцэтгэж байгаа цалин хөлстэй болон орлого олох үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа, мал маллахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацаа, гэрийн ажилд зарцуулж байгаа дундаж хугацаа, асрахуйн ажилд зарцуулж буй дундаж хугацаа, болон хоногт бусад үйл ажиллагаанд зарцуулж байгаа дундаж хугацааг тус тус авсан бөгөөд энгийн регрессийн тэгшитгэлийг (1)-(5) гэж харгалзуулан

дугаарласан болно. Регрессийн тэгшитгэл (1)-ээс, цалин хөлстэй, орлого олох үйл ажиллагаанд зарцуулах хугацаанд нөлөөлж байгаа хүчин зүйл нь боловсролын хүчин зүйл байгаа нь харагдаж байна. Боловсролын суурь буюу жишиг хувьсагчаар боловсролгүй хувьсагчийг авлаа. боловсролын зэрэг бага байх тусам цалин хөлстэй ажил эрхлэлт болон бусад орлого олох үйл ажиллагаанд бага хугацаа зарцуулжээ. Дээд боловсролтой нөхцөлд өдөрт дундажаар 194 минут илүү хугацааг, бага боловсролтой бол өдөрт дундажаар 13 минут бага хугацааг, бүрэн дунд боловсролтой бол 77.8 минут илүү хугацааг тус тус цалин хөлстэй ажилд зарцуулж байна. 2019 онтой харьцуулахад 2011 оны хувьд энэхүү үйл ажиллагаанд орон нутгийн иргэд маш 11 минут илүү зарцуулсан байна. Хөдөө буюу малын бэлчээр дээр байгаа малчдын хувьд 119 минутаар бага хугацаа, малтай өрхийн хувьд 63 минут бага хугацааг энэхүү цалин хөлстэй үйл ажиллагаанд зарцуулж байна. Харин хавар, зун, болон намрын улиралалд өвлийн улиралтай харьцуулахад цалин хөлстэй үйл ажиллагаанд илүү хугацааг дундажаар зарцуулж байна. Өрхийн ам бүл “тэжээх” ам бүл ихсэх тутам цалин хөлстэй ажилд зарцуулах хугацаа 72 минутаар бага байгаа нь бага насны хүүхдийг асрах цаг өссөнтэй холбоотой байж болно. Харин эмэгтэйчүүдийн цалин хөлстэй үйл ажиллагаа эрхлэх дундаж хугацаа эрчүүдийнхээс 23 минутаар бага байгаа нь эмэгтэйчүүд ихэвчлэн үнэлгээгүй гэрийн ажилд хөдөлмөр цагаа зарцуулж байгаагаар тайлбарлагдана. Бүсийн хувьд хөдөө орон нутгийн иргэд зүүн бүстэй харьцуулахад статистикийн хувьд ач холбогдолгүй байгаа тул хөдөө орон нутгийн болон малчдын хувьд цалин хөлстэй ажил эрхлэлтэнд бүсийн нөлөөлөл бага байгааг харуулж байна.

Дараагийн тэгшитгэл (2) нь мал маллахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулах дундаж хугацаанд нөлөөлж байгаа хувьсагчдын нөлөөллийг харуулж байна. Хөдөө орон нутагт оршин суугаа бүрэн дунд боловсролтой иргэд боловсролгүй иргэдтэй харьцуулахад өдөрт дундажаар 17 минут, дээд боловсролтой хүний хувьд өдөрт дундажаар 72 минут бага хугацааг мал маллах үйл ажиллагаанд зарцуулж байна. 2011 онтой харьцуулахад дундажаар мал маллах хугацаа 32 минутаар бага байна. Монголчуудын уламжлалт мал аж ахуйд 5-аас дээш насны гэр бүлийн бүх гишүүд хурга ишиг хариулах, тугал татах, хурдны морь унах гэх мэтээр оролцдог тул 5 ба түүнээс насны гишүүдийн мал маллах үйл ажиллагаанд зарцуулах хугацаанд нөлөөлөх нөлөөллийг авч үзсэн ч статистикийн хувьд ач холбогдолгүй гарлаа. Харин хөдөөний буюу малчдын хувьд өдөрт дундажаар 249.5 минут илүү, малтай өрхийн хувьд 107 минут илүү хугацааг тус тус энэхүү үйл ажиллагаанд зарцуулж байна. Харин өвлийн улиралтай улирлын хувьд хавар 4 минут бага хугацааг, зун 54 минут бага хугацааг, намар 121 минут бага хугацааг тус тус мал маллах үйл ажиллагаанд зарцуулж байна. Харин харин эмэгтэйчүүд эрчүүдтэй харьцуулахад өдөрт дундажаар 128.8 минут бага цаг хугацааг мал маллах үйл ажиллагаанд зарцуулж байна. Бүсийн хувьд зүүн бүстэй харьцуулахад хангайн болон төвийн бүсүүд харгалзан дундажаар 20 минут, 29 минут илүү хугацааг зарцуулж байгаа бол баруун бүс зүүс бүсийн хувьд энэхүү ялгаа статистикийн хувьд

ач холбогдолгүй байна.

Тэгшитгэл (3)-н хувьд гэрийн ажилд зарцуулах дундаж хугацаанд нөлөөлөх хүчин зүйлийг авч үзэхэд боловсролын түвшний хувьд бага, бүрэн дунд боловсролын хувьд хамааралгүй байгаа хэдий ч дээд боловсролтой иргэдийн хувьд дундажаар 51 минут бага хугацааг гэрийн ажилд зарцуулж байна. 14 ба түүнээс дээш өрхийн гишүүдийн тоо өсөх тутам гэрийн ажилд зарцуулах хугацаа 7 минутаар буурч байгаа бол 2 ба түүнээс доош настай хүүхэдтэй өрхийн хувьд энэхүү үзүүлэлт 4.3 минутаар илүү байна. Аргал түүдэг өрхийн хувьд энэхүү хугацааг дундажаар 11.9 минутаар илүү байгаа бол угаалгын машин хэрэглэдэг өрхийн хувьд 7.7 минутаар бага хугацааг зарцуулж байна. Харин цахилгаан төвийн шугамд холбогдсон өрхийн хувьд энэхүү хугацаа 14.1 минутаар илүү, хөдөөгийн малчдын хувьд энэхүү хугацаа 10.2 минутаар бага, малтай өрхийн хувьд энэхүү хугацаа 7.9 минутаар илүү хугацааг тус тус зарцуулж байна. Харин хаврын улиралд дундажаар 7.7 минут бага харин намар 22.7 минут илүү хугацааг гэрийн ажилд зарцуулж байна. Эмэгтэйчүүд өдөрт дундажаар 170.4 минут илүү хугацааг гэрийн ажилд зарцуулж байна. Бүсийн хувьд ялгаатай байдал харагдаж байгаа бөгөөд зүүн бүстэй харьцуулахад баруун бүсийнхэний хувьд дундажаар 18.9 минут илүү, хангайн бүсийнхэний хувьд 9.3 минут бага хугацааг, төвийн бүсийнхэний хувьд 13.4 минут бага хугацааг гэрийн ажилд тус тус зарцуулж байна.

Тэгшитгэл (4)-н хувьд хөдөө орон нутгийн иргэдийн асрахуйн үйл ажиллагаанд зарцуулж байгаа дундаж хугацаанд нөлөөлөх хүчин зүйлийг харуулж байна. Үүнд боловсролгүй иргэдтэй харьцуулахад бага боловсролтой иргэд өдөрт дундажаар 6 минут илүү хугацааг, бүрэн дунд боловсролтой иргэдийн хувьд 5.5 минут илүү хугацааг, харин дээд боловсролтой иргэдийн хувьд 9.8 минут илүү хугацааг дундажаар тус тус зарцуулж байна. 2019 оны хувьд дундаж асрахуйн ажилд зарцуулах хугацаа нь 2011 оны асрахуйн ажилд зарцуулах хугацаа дундажаар 6.2 минутаар бага, харин 2015 оны энэ хугацаа 4.9 минутаар тус тус бага байна. Бага насны хүүхэдтэй буюу 2 ба түүнээс доош насны хүүхэдтэй хөдөө орон нутгийн иргэдийн хувьд өдөр дундажаар 46.5 минут илүү, 2-6 насны хүүхэдтэй хүний хувьд дундажаар 14.1 минут илүү хугацааг асрахуйн үйл ажиллагаанд тус тус зарцуулж байна. Харин 60 ба түүнээс дээш настай өрхийн гишүүдтэй байгаа нөхцөлд өдөрт дундажаар 4.7 минут илүү хугацааг зарцуулж байна. Хөдөөний буюу малчдын хувьд энэхүү үйл ажиллагаанд 15.2 минут бага хугацааг, малтай өрхийн хувьд 9.3 минут бага хугацааг тус тус зарцуулж байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд 24.7 минут илүү хугацааг өдөрт дундажаар асрахуйн үйл ажиллагаанд зарцуулж байна. Бүсийн хувьд асрахуйн үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааны ялгаатай байдал харагдахгүй байна.

Тэгшитгэл (5)-н хувьд хамаарах хувьсагчийг сайн дурын ажил, боловсролд зарцуулах хугацаа, чөлөөт цаг болон өөрийгөө асрахуйд зарцуулж байгаа дундаж хугацааны нийлбэрээр авсан бөгөөд энэхүү хувьсагчид боловсролгүй иргэдтэй харьцуулахад бага боловсролтой иргэд дундажаар 23.4 минут илүү, бүрэн дунд боловсролтой иргэдийн

хувьд 58 минут бага, дээд боловсролтой иргэдийн хувьд 78.9 минут илүү хугацааг тус тус зарцуулж байна. 2019 онтой харьцуулахад 2011 оны хувьд 9.2 минут бага хугацааг зарцуулж байгаа нь харагдаж байна. Хөдөөний иргэдийн хувьд энэхүү хугацаа 43.7 минут бага, тэр дундаа малчдын хувьд энэхүү хугацаа 21.1 минут бага, хаврын цагт 26 минут бага, зуны цагт 12.7 минут бага, намрын цагт 24 минут илүү хугацааг тус тус зарцуулж байгаа нь харагдаж байна. Эмэгтэйчүүдийн хувьд 47.2 минут бага хугацааг зарцуулсан байна. Гэрийн ажлыг хөнгөвчлөх болон гэрийн ажлыг нэмэх хүчин зүйлс, тухайлбал, нарны панель, угаалгын машин, усаа зөөдөг эсэх, аргал түүдэг эсэх, төвийн цахилгаантай эсэх зэрэг үзүүлэлтүүдийн нөлөөг үзэхэд нарны панельтай өрхийн гишүүдийн хувьд энэхүү үйл ажиллагаанд зарцуулах цаг 44.8 минут бага, усаа зөөдөг бол 13 минутаар илүү цаг, угаалгын машин ашигладаг бол 21 минут бага цаг, төвийн цахилгаантай бол 59 минутыг илүү зарцуулж байгаа нь харагдаж байна. Гэхдээ энэ тэгшитгэлийн хүчин зүйлийн хамаарлын нөлөөг бид болгоомжтой хандах ёстой. Учир нь бид нийт цаг ашиглалтын 1440 минутаас өөрсдийн сонирхож байгаа цалин хөлстэй ажил эрхлэхэд зарцуулж байгаа хугацаа, мал маллахад зарцуулж байгаа хугацаа, гэрийн болон асрахуйн ажилд зарцуулж байгаа хугацааг ялган авч үлдсэн хугацааг нэгтгэн бусад гэсэн хувьсагчаар төлөөлүүлж үзсэн. Судалгааны зорилготой шууд хамаарахгүй үйл ажиллагааны цагийн зарцуулалтыг бусад гэж авч хамруулсан нь тэгшитгэл (5)-ийн үр дүнд нөлөөлсөн байх боломжтой. Бүсийн нөлөөллийн хувьд зүүн бүстэй харьцуулахад баруун бүсийн орон нутгийн иргэдийн хувьд 34 минут бага, харин төвийн бүсийн хувьд 16.3 минут бага хугацааг тус тус зарцуулж байна.

Дүгнэлт:

Энэхүү судалгаагаар хөдөө орон нутгийн 18 ба түүнээс дээш насны иргэдийн 2011, 2015 болон 2019 оны ЦАС-ны өгөгдлийг ашиглан, хөдөө орон нутгийн иргэдийн цаг ашиглалтанд нөлөөлж байгаа хүчин зүйлс нь хүйсийн хувьд болон бусад хүчин зүйлсийн хувьд хэр ялгаатай байгааг энгийн регрессийн аргаар шинжилж үзлээ. Мөн үйл ажиллагаа тус бүрийн цаг ашиглалтын судалгааг хүйсийн хувьд болон бүсүүдийн хувьд ямар ялгаатай байгааг судаллаа. Судалгааны үр дүнгээс харахад, мал аж ахуйн салбарын үйл ажиллагаанд хөдөө орон нутгийн малчин эрчүүд илүү цаг зарцуулж байна. Хэдийгээр мал маллах үйл ажиллагаа нь цалин хөлсгүй ч мал аж ахуйн бүтээгдэхүү нь шууд мөнгөн орлого болох боломжтой үйл ажиллагаа юм. Харин зах зээлийн үнэлгээгүй гэрийн ажил болон асрахуйн ажил буюу эдийн засгийн бүрэн утгаараа зах зээлд үнэлүүлэх боломжгүй, шууд мөнгөн орлогод хувирах боломжгүй үйл ажиллагаанд хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд түлхүү цагийг зарцуулж байгаа хэв шинж нийтлэг харагдаж байна. Хэдийгээр мал аж ахуйн салбар нь бүрэн өрхийн аж ахуйд суурилсан мянга мянган малчин өрхөөс бүрддэг, мал маллах үйл ажиллагаа нь цалин хөлсгүй боловч тухайн өрхийн зах зээлд орлого олох боломжтой ажилд малчин эрчүүд илүү цагийг зарцуулж харин эмэгтэйчүүд үнэлгээгүй ажил буюу гэрийн болон асрахуйн ажилд илүү их цагийг зарцуулж байна. Энэ нь мал аж ахуйгаас олох орлого харьцангуй тухайн өрхийн

эрэгтэйчүүдэд төвлөрөх нөхцлийг бүрдүүлж өгөх магадлалтай. Эмэгтэйчүүдийн хувьд зах зээлийн үнэлгээгүй ажил буюу гэрийн ажил болон асрахуйн ажилд илүү цагийг өдөрт дундажаар зарцуулж байгаа тул энэхүү дур зургаар харахад хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд мөнгөн орлогын хувьд харьцангуй бусдаас хамааралтай байх боломжтойг илтгэн харуулж байна.

Ашигласан материал

1. Bhagowalia, P., Menon, P., Quisumbing, A., & Soundararajan, V. (2012). What Dimensions of Women's Empowerment Matter Most for Child Nutrition? IFPRI Working Paper 01192, Washington, DC.
2. Chayanov, A. (1991). The theory of peasant co-operatives. Columbus: Ohio State University Press.
3. Doss, C. (2013). Intrahousehold Bargaining and Resource Allocation in Developing Countries. World Bank Research Observer, 28(1), 52–78.
4. Folbre, N. (2006). Measuring Care: Gender, Empowerment, and the Care Economy. Journal of Human Development, 7(2), 183–199. <https://doi.org/10.1080/14649880600768512>
5. Kadiyala, S., Harris, J., Headey, D., & Gillespie, S. (2014). Agriculture and nutrition in India: Mapping evidence to pathways. Annals of the New York Academy of Sciences, 1331(1), 43–46. <https://doi.org/10.1111/nyas.12477>
6. Mazzotta, F., Papaccio, A., & Parisi, L. (2019). Household Management Systems and Women's Decision Making Within the Family in Europe. Feminist Economics, 25(4), 126–158. <https://doi.org/10.1080/13545701.2019.1658887>
7. Seguino, S. (2020). Engendering Macroeconomic Theory and Policy. Feminist Economics, 26(2), 27–61. <https://doi.org/10.1080/13545701.2019.1609691>
8. Seymour, G., Malapit, H., & Quisumbing, A. (2020). Measuring Time Use in Developing Country Agriculture: Evidence from Bangladesh and Uganda. Feminist Economics, 26(3), 169–199. <https://doi.org/10.1080/13545701.2020.1749867>
9. UNSD. (2008). System of National Accounts. Washington, DC: United Nations.
10. ҮСХ. (2011, 2015, 2019). Цаг ашиглалтын хүснэгт. Улаанбаатар, Монгол Улс: Үндэсний Статистикийн Хороо.
11. ҮСХ. (2023). Дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, салбараар. Улаанбаатар, Монгол Улс: Үндэсний Статистикийн Хороо.